

ХОВД АЙМГИЙН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН
2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2022-12-12

Гүйцэтгэлийн хувь = (Хүрсэн түвшин – Суурь түвшин) / (Зорилтот түвшин – Суурь түвшин) * 100%

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<i>Бодлогын зорилт: АЗДҮАХ - 2.3.7,</i>							
1	Зорилт-1 Тогтвортой хөгжлийн боловсрол орон нутгийн дэд хөтөлбөрийг, хэрэгжүүлэх	ОНХС 30 сая	Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	51,9	70	Орон нутгийн дэд хөтөлбөр 4 зорилтын хүрээнд 16 арга хэмжээ зохион байгуулсан. Хэрэгжилтийн дундаж биелэлт 63%-тай. Энэ жил дэд хөтөлбөрөөс 6,936,000 төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа зохион байгуулсан. “Тогтвортой хөгжлийн боловсрол”-ын интеграц хичээлийн 72 хөтөлбөр боловсруулж, ЕБ-ын 25 сургуульд 108 ширхэг 5 төрлийн гарын авлага ном түгээв. Энэ хугацаанд хөтөлбөрийн хүрээнд төслөөс 42,800,000 төгрөгийн санхүүжилт зарцуулав. Орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, ус цахилгааны хэрэглээг хянах, зохистой ашиглах талаар сурагчид болон эцэг эхчүүдэд ойлголт өгч, амьдралд ашиглах мэдлэг мэдээлэлтэй болсон. Хүрсэн түвшин 100%	100
1.1	Сургууль бүхлээрээ ажиллах арга, хандлагыг сургуулийн үйл ажиллагаанд түгээх	ОНХС 10,2 сая	Сургуулийн тоо	4	12	Тогтвортой хөгжлийн боловсрол-2 төслийн зорилтот сургууль болох Мөнххайрхан, Буянт, Жаргалант 1, 2 дугаар сургуулиуд аймгийн төвийн 8 сургууль, 16 цэцэрлэгт сургууль, бүхлээрээ ажиллах арга зүйг түгээн дэлгэрүүлэх сургалт, өдөрлөг зохион байгуулав. Орон нутгийн түвшинд “ТХБ үндэсний болон орон нутгийн хөтөлбөрийн хэрэгжилт-үр дүн” сэдэвт бүтээлч ажлын үзэсгэлэн гарган 5 сургууль, 2 цэцэрлэг, 1 эко клубийн үйл ажиллагааг сурталчлах, туршлага солилцох арга хэмжээг зохион байгууллаа. Мөн “Тогтвортой хөгжлийн боловсрол – Ховд “page цахим хуудас ажиллуулан үйл ажиллагаагаа олон нийтэд түгээж байна. Цахим хуудасны идэвхтэй гишүүдийн тоо 787 болж өмнөх жилээс 500-аар нэмэгдсэн байна. Мөн сургууль бүр цахим хуудас нээн ажиллуулж байна.	100

						Хүрсэн түвшин 12	
1.2	Олон улсын эко сургуулийн хөтөлбөр хэрэгжүүлэх	ОНХС 10 сая	сургуулийн тоо	19	24	Тогтвортой хөгжлийн боловсрол, эко сургуулийн үзэл баримтлал арга зүйн сургалтад нэмж 7 сургууль оролцоноор нийт 24 сургууль 100% хамрагдлаа. Мөн 7 цэцэрлэгт эко цэцэрлэгт анхан шатны сургалтад Байгаль орчин мэдээлэл сургалтын төвтэй хамтран зохион байгуулав . Сургалтад нийт 64 багш, сурагч, эцэг эх ажилчдын төлөөлөл оролцов. Хүрсэн түвшин 24	100
1.3	Олон нийтийн оролцоот сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг тогтворжуулах	Үйл ажиллагаа	ОНО сургууль, цэцэрлэгийн тоо	сургууль 13, цэцэрлэг 6	Сургууль 16 Цэцэрлэг 12	Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог өргөжүүлэх ажлыг сургууль, цэцэрлэгийн зөвлөлөөр дамжуулан хэрэгжүүлэхээр төлөвлөн 17 сумын сургууль, цэцэрлэгийн зөвлөлийг шинэчлэн байгуулав. ОНОС-ын үнэлгээ хийгдээгүй байна. Хүрсэн түвшин 17	100
1.4	Хоггүй -Ногоон Ховд зорилтод бүтээлч аян	ОНХС 6 сая	Оролцогч байгууллагуудын тоо	58	100	“Хоггүй -Ногоон Ховд”- аян 25 сургууль 33 цэцэрлэгийн дунд зохион явуулаа. Тус аянд 24 сургууль 33 цэцэрлэг оролцоноос 5 шалгуурын дагуу үнэлж дүгнэв. Сургуулиас Прогресс, Манхан, Дөргөн, цэцэрлэгээс Жаргалант 1, 16, 15, 2, 3 дугаар цэцэрлэгүүд манлайлан оролцлоо. Урамшуулалд 3,400,000 төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн дэд хөтөлбөрөөс дэмжин олгосон Хүрсэн түвшин 100%	100
1.5	Сайн дурын сурагчдын эко клубуудын үйл ажиллагааг сайжруулах	ОНХС 11 сая	Үйл ажиллагааны тоо	0	3	1. ЕБС-уудын эко клубийн нэгдсэн судалгаа хийв. ЕБ-ын 24 сургуульд сайн дурын 24 эко клуб нийт 648 гишүүнтэй ажиллаж байна. Эко клубуудын гишүүдийн тоо харилцан адилгүй, хамгийн их нь 70, бага нь 10 гишүүнтэй байна. 2. Эко сургуулийн анхан шатны сургалтад 15 сурагч, ТХБ-2 туршлага солилцох өдөрлөгт 18 сурагч хамруулж нийт 33 сурагчийг чадваржуулав. 3. Прогресс сургуулийн сурагчдын “Гүзээлзгэнэ” клубийн болон 16 дугаар цэцэрлэгийн багачуудын үйл ажиллагааг өдөрлөгийн үеэр нийтэд сурталчлав. Мөн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд бусад сургуулийн клубуудын үйл ажиллагааг сурталчлах ажлыг нээлттэй зохион байгуулав. Хүрсэн түвшин 3	100
Бодлогын зорилт: АХТЖҮЧ - 2.1.1, АЗДҮАХ - 2.3.3,							

2.	Зорилт -2 Хамран сургалтыг нэмэгдүүлэх	Үйл ажиллагаа	Хамрагдалт ын хувь	5 настай хүүхдийн 98%-ийг СӨБ-д, бага боловсрол 95 % суурь боловсрол 95,8%	5 настай хүүхдийн 98,5%-ийг СӨБ-д бага боловсрол 96 %, суурь боловсрол 96,3%	<p>2022-2023 оны хичээлийн жилд СӨБ-ын 41 цэцэрлэгт өдрийн болон хувилбарт сургалтаар 250 бүлэгт 7504 хүүхэд хамрагдаж байгаа бөгөөд өдрийн 227 бүлэгт 6618 хүүхэд хамрагдаж байна. Хувилбарт сургалтаар 23 бүлэгт 877 хүүхэд хамрагдаж байна.</p> <p>Хүн амын тооноос тооцоход 2-5 насны 8947 хүүхэд цэцэрлэгт хамрагдахаар байгаагаас 2022 оны СӨБ-ын хамран сургалтын бохир жин 83,9%-тай байгаа нь хагас жилээс 6,4%-аар нэмэгдсэн, СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин 81,5%, Цэцэрлэгийн хамран сургалтын бохир жин 74%, цэцэрлэгийн хамран сургалтын цэвэр жин 71,3%-тай байна.</p> <p>Сургуулийн өмнөх боловсролд 5 настай 1932 хамрагдаж хамрагдах 5 настай нийт хүүхдийн 91,9%-ийг хамруулаад байна.</p> <p>2022 оны жилийн эцсээр ерөнхий боловсролын 25 сургуулийн 752 бүлэгт өдрөөр 20966 хүүхэд суралцаж байгаагаас бага боловсролын 336 бүлэгт 10412 хүүхэд, дунд ангийн 259 бүлэгт 7063 хүүхэд, ахлах ангийн 157 бүлэгт 3491 хүүхэд суралцаж байна.</p> <p>Бага боловсролын хамран сургалтын бохир жин нь 95,6%, Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 95,4% байна.</p> <p>Суурь боловсролын хамран сургалтын бохир жин нь өөрөөр хэлбэл 11-14 насны сурч байгаа хүүхэд 94,8%, Суурь боловсролын цэвэр жин буюу дунд ангид сурч байгаа 11-14 насны хүүхдийн эзлэх хувь 91 байна.</p>	88.8
2.1	Хамран сургалтын тойргийн хүүхдийн судалгаа гаргах	Үйл ажиллагааны зардал	СӨБ, ЕБС—д хамрагдах хүүхдийн судалгаа	Сургууль, цэцэрлэг бүрээр гарсан	Аймгийн хэмжээнд нэгтгэн гаргах	Цэцэрлэг, сургуулиудад хамран сургах тойргийг тогтоохдоо аймгийн төвд сургуулийн хүчин чадал болон тухайн сургуулийн ойр орчмын айл өрхийг байрны дугаар, гудамжаар хуваарилж 1 дүгээр ангийн элсэлтийг 8 дугаар сарын 10-29-ний өдрүүдэд цахимаар зохион байгуулсан. Хамран сургах тойргийн хүүхдийн тоон мэдээлэл болон хүүхдийн нэрсийг аймгийн статистикийн хэлтсээс авч харьяалах сургууль цэцэрлэгүүдэд хүргүүлэн сургууль, цэцэрлэгт хамрагдаж байгаа сурагчдыг бүртгэж хяналтадаа авч ажиллаж байна. Сургуулийн гадна байгаа хүүхдийн мэдээллийг салбарын байгууллагаар хяналт	90

						хийлгүүлэн гаргасан Үүнд сургуулийн гадна байгаа сургуульд огт ороогүй завсардсан 3, сургуульд ороод 2, 3, 6 дугаар ангиас гарч завсардсан 3 нийт 6 сурагч байгааг хамран сургах тойргийн сургуульд хамруулах, дүйцсэн хөтөлбөрөөр суралцуулахад дэмжлэг үзүүлэхийг үүрэг болгосон. Эдгээр сурагчид нь өвчний улмаас болон хөгжлийн бэрхшээлтэй хөдөө сумын суралцагч нар юм.	
2.2	Боловсролын үйлчилгээнд сурагчдыг бүрэн хамруулах	Үйл ажиллагааны зардал	СӨБ, ЕБС-ийн хамрагдалтын хувь	СӨБ-60,4%, бага боловсрол 95%, суурь 95,8%	СӨБ-70%, бага боловсрол 96%, суурь 96,3%	<p>2022-2023 оны хичээлийн жилд СӨБ-ын 41 цэцэрлэгт өдрийн болон хувилбарт сургалтаар 250 бүлэгт 7504 хүүхэд хамрагдаж байна.</p> <p>2022 оны СӨБ-ын хамран сургалтын бохир жин 83,9%-тай байгаа нь хагас жилээс 6,4%-аар нэмэгдсэн, СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин 81,5%, Цэцэрлэгийн хамран сургалтын бохир жин 74%, цэцэрлэгийн хамран сургалтын цэвэр жин 71,3%-тай байна.</p> <p>2022 оны жилийн эцсээр ерөнхий боловсролын 25 сургуулийн 752 бүлэгт өдрөөр 20966 хүүхэд суралцаж байна.</p> <p>Бага боловсролын хамран сургалтын бохир жин нь 95,6%, Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 95,4% байна.</p> <p>Суурь боловсролын хамран сургалтын бохир жин нь өөрөөр хэлбэл 11-14 насны сурч байгаа хүүхэд 94,8%, Суурь боловсролын цэвэр жин буюу дунд ангид сурч байгаа 11-14 насны хүүхдийн эзлэх хувь 91 байна</p> <p>“Сургуульд хүүхдийг амжилттай бэлтгэх нь” сэдэвт хэлэлцүүлгийг Жаргалант сумын 14 дүгээр цэцэрлэгтэй хамтран 2022 оны 04 дүгээр сарын 06 ны өдөр бүх цэцэрлэгийн дунд зохион байгууллаа. Энэхүү хэлэлцүүлэгт бага ангийн багш, сургалтын менежер, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш нарыг төлөөлөл бүхий 90 гаруй хүн оролцож, 60 гаруй санал гаргаж, тэдэнд санал зөвлөгөө өглөө. 1 дүгээр ангид элсэн суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгаа гаргаж сургууль, багш нарт мэдээлэл хүргэж эцэг эхтэй нь уулзаж аль сургуулийн хэн багшийн ангид өгөх талаар ярилцлаа. Хараа, аутизмын хүрээний эмгэгтэй хүүхэдтэй ажиллах багш нарт зун брайл сурч ирэх талаар мэдээлэл хүргэлээ. Сурах бичиг, сонсох төхөөрөмжийг БШУЯ-с авч III, YI сургуульд өглөө.</p>	85

2.3	Гэрээр боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны зардал	Хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн тоо	0	120	Ахлах бэлтгэл бүлгийн хүүхдэд зориулсан дасгал ажлын дэвтэрийг мэргэжлийн бүлгээрээ хэлэлцүүлэн, суралцаж байгаа 5 болон 6 настай хүүхдэд зөвлөмжийг гэрээр материалыг эцэг эхчүүдэд хүргэж ажиллаа. Хөдөөгийн сумдаас Дарви, Мянгад, Дөргөн, Жаргалант 8,13 дугаар цэцэрлэгүүд маш идэвхтэй бүтээлчээр хандаж, 300 гаруй материалыг тараасан байна.	90
2.4	Дотуур байрын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	Улсын төсөв	Хамрагдалтын хувь	95%	97%	2021-2022 оны хичээлийн жилд дотуур байранд нийт 1886 сурагч суух хүсэлт гаргаснаас 1726 сурагч хамрагдсан нь 91,6 % эзэлж байна. Хөшөөтийн уурхайн тосгон сумын төвд ойрхон байгуулагдсан тул Цэцэг сумын дотуур байранд хүсэлт гаргасан хүүхдийн 20% нь гэрээсээ суралцаж байна. Мөн зорилтот хүүхдийн тоон судалгааг гаргахад Эмзэг бүлгийн 1922 бүтэн өнчин-43, хагас өнчин-875, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 2600, нэн ядуу 276 үүнээс дотуур байранд бүтэн өнчин 3, хагас өнчин 206 хүүхэд амьдарч байна. Хүүхэд хамгааллын үйлчилгээний дагуу 5 хүүхэд дотуур байранд амьдарч байна. Манхан, Дөргөн Үенч, Эрдэнэбүрэн сумдын өргөтгөл болон засвар үйлчилгээ хийгдсэн. Минжит булган цогцолбор сургуулийн хатуу зөөлөн эдлэлийн шинэчлэлийг 55 сая төгрөгөөр ОНХС-аас шинэчлэх тендер зарлагдаж “Минж төгөл” ХХК шалгарч нийлүүлэлт хийж байна. Хөшөөт хөгжил сангаас 75 ширхэг шкаф, 300 ширхэг зөөлөн эдлэлийн санхүүжилт шийдвэрлэгдэж тендер зарлагдаж нийлүүлэлт хийх компаниуд шалгарсан байна	90
Бодлогын зорилт: АХТЖҮЧ- 2.1.6, АЗДҮАХ- 2.3.9,							
3	Зорилт -3 “Чадварлаг багш, оюутан, сурагч” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх	ОНХС 50 сая	Хэрэгжилтийн хувь	32%	60%	Орон нутгийн дэд хөтөлбөрийн хүрээнд багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажлын үнэлэмжийг нэмэгдүүлэх, нэр хүндийг өсгөх зорилгоор “Чадварлаг багш” шалгаруулах болзол гаргаж шагнаж урамшуулж байна. 2021 онд 5 багшийг 13.8 сая, 2022 онд мөн 5 багшийг 21 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа. Мөн элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт үзүүлсэн 13 суралцагчийг 6,9 сая төгрөгөөр, аймагтаа тэргүүлсэн 3 сургуулийг 8.76 сая төгрөгөөр, улсын хэмжээнд амжилт гаргасан мэргэжилтэн багш нарыг шагнаж нийт дүнгээрээ 39,460 мянган төгрөгийн санхүүжилт олголоо.	62

						<p>2021 онд Аймгийн засаг даргын нэрэмжит “Чадварлаг мэргэжилтэн-Шинэ Ховдын ирээдүй” тэтгэлэгт хамрагдах хүсэлт гаргасан 15 оюутны материалыг хэлэлцээд журмын шаардлага хангасан 13 оюутанд дэмжлэг урамшууллыг олгосон.</p> <p>2022 онд 80 сая төгрөгийн санхүүжилтыг төлөвлөн хэрэгжүүлэхээр баталж хэрэгжүүлж байна.</p> <p>Бид Ховдын хүүхдүүд аяныг 2022 оны 02 сарын 14-ны өдрөөс эхлэн тусгай удирдамж гарган хэрэгжүүлж ажилласан. 2021-2022 оны хичээлийн жилд 25 сургууль 33 цэцэрлэгийн нийт 58 байгуулагууд хичээл сургалтын үйл ажиллагаандаа дадал хэвшил болгон сурагч болон цэцэрлэгийн хүүхдүүдээр нутгийн уул ус, домог түүх, олон угсаатны бүжиг, дуу, тоглоом наадгай, судалгааны ажил гэх мэт 996 үйл ажиллагаанудыг зохион байгуулж сургууль цэцэрлэгийн 490 бүлгийн 14547 хүүхэд багачууд аянд оролцож сошиал бүлгүүдээр үйл ажиллагаануудыг түгээн дэлгэрүүлж 65875 хүний хандалт авч 8000 гаруй эерэг сэтгэгдлүүдийг үлдээсэн байна. Цаашид бид багш сурагчид хүүхэд багачуудынхаа Ховдын хүүхдүүд сэтгэлгээ хийж буй ажлууд өв соёлоо түгээн дэлгэрүүлэх тал дээр илүү ихийг хийж ажиллах хэрэгцээ шаардлага зайлшгүй байна. Аяны хүрээнд сургууль цэцэрлэгүүд 15.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтуудыг хийж материаллаг баазаа бүрдүүлж байна.</p>	
3.1	Олон улс болон улсын түвшинд амжилт гаргасан багш, сурагч, оюутнуудыг дэмжих урамшуулах	20 сая	Багш, сурагч, оюутны тоо	ЭЕШ-д амжилт гаргасан 33 багш, 25 сурагчийг урамшуулсан	Урамшуулсан багш, сурагч оюутны тоо нэмэгдсэн байна.	<p>Цаст-Алтай цогцолбор сургуулийн багш Д.Баасанжав улсын мэдээлэл зүйн хичээлийн олимпиадад 2-р байр, мөнгөн медаль хүртэж 2.0 сая төгрөгөөр шагнууллаа.</p> <p>2022 оны ЭЕШ шалгалтад бэлтгэсэн шавь 800 оноо авсан Прогресс сургуулийн сурагч Баасанжав овогтой Энхзүл, бэлтгэсэн багш Прогресс сургуулийн багш Баяртунгалагийг 1 сая төгрөгөөр шагнасан. Аймгийн ЗДТГ, болон АИТХ-аас багш сурагч оюутныг дэмжин ажиллаж байна.</p>	70
3.2	Орон нутгийн мэргэжилтэй боловсон хүчний эрэлттэй нийцүүлэн оюутныг тэтгэлэгт хамруулах	10 сая	Оюутны тоо	9	10	<p>Орон нутгийн дэд хөтөлбөрийн хүрээнд багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажлын үнэлэмжийг нэмэгдүүлэх, нэр хүндийг өсгөх зорилгоор “Чадварлаг багш” шалгаруулах болзол</p> <p>“Чадварлаг мэргэжилтэн-Шинэ Ховд” аймгийн засаг даргын нэрэмжит тэтгэлэг олгох журмын болзол, шалгуурыг Ховд</p>	90

					<p>аймгийн Засаг даргын тамгын газрын вэб сайт, сургуулиудад мэдээлэл хүргүүлж шалгаруулалтыг хүргэн ажиллаж байна. 2021 онд 5 багшийг 13.8 сая, 2022 онд мөн 5 багшийг 21 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа.</p> <p>Мөн элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт үзүүлсэн 13 суралцагчийг 6,9 сая төгрөгөөр, аймагтаа тэргүүлсэн 3 сургуулийг 8.76 сая төгрөгөөр, улсын хэмжээнд амжилт гаргасан мэргэжилтэн багш нарыг шагнаж нийт дүнгээрээ 39,460 мянган төгрөгийн санхүүжилт олголоо.</p> <p>2021 онд Аймгийн засаг даргын нэрэмжит “Чадварлаг мэргэжилтэн-Шинэ Ховдын ирээдүй” тэтгэлэгт хамрагдах хүсэлт гаргасан 15 оюутны материалыг хэлэлцээд журмын шаардлага хангасан 13 оюутанд дэмжлэг урамшууллыг олгосон. Энэ хичээлийн жилд өнгөрсөн хичээлийн жилийн тэтгэлэг авсан 5 оюутныг үргэлжлүүлэн тэтгэлэгт хамруулж, шинээр 20 оюутанд тэтгэлэг олгуулахаар болзлыг зарлаад байна.</p>		
3.3	Бид Ховдын хүүхдүүд аян зохион байгуулах;	10 сая	Аян зохион байгуулах	2019 онд зохион байгуулсан	Оролцогчдын тоо нэмэгдсэн байна.	<p>Дэд хөтөлбөрүүдийн хүрээнд “Бид Ховдын хүүхдүүд” аяны удирдамжуудыг батлан хэрэгжүүллээ.</p> <p>Бид Ховдын хүүхдүүд аянд 25 сургуулийн 12000 гаруй сурагч, 33 цэцэрлэгийн 3000 гаруй хүүхэд багачууд 1089 эх, эцэг, багш, ажилтан хамрагдсан нь өмнөх жилүүдийнхээс өссөн байна.</p> <p>“Бид ховдын хүүхдүүд” цахим рүүпээр аяны хүрээнд хийж байгаа үйл ажиллагааг нийтэд сурталчлан, хэрэгжилтийг үнэлэн ажиллаж байна.</p> <p>25 сургууль 33 цэцэрлэгийн нийт 58 байгуулагууд хичээл сургалтын үйл ажиллагаандаа дадал хэвшил болгон сурагч болон цэцэрлэгийн хүүхдүүдээр нутгийн уул ус, домог түүх, олон угсаатны бүжиг, дуу, тоглоом наадгай, судалгааны ажил гэх мэт 996 үйл ажиллагаануудыг зохион байгуулж сургууль цэцэрлэгийн 490 бүлгийн 14547 хүүхэд багачууд аянд оролцож “Бид Ховдын хүүхдүүд”, “Багшийн хөгжил-Боловсрол, шинжлэх ухааны газар” гэсэн сошиал бүлгүүдээр үйл ажиллагаануудыг түгээн дэлгэрүүлж 65875 хүний хандалт авч 8000 гаруй эерэг сэтгэгдлүүдийг үлдээсэн байна. Цаашид бид багш сурагчид хүүхэд багачуудынхаа Ховдын хүүхдүүд сэтгэлгээ хийж буй ажлууд өв соёлоо түгээн дэлгэрүүлэх тал дээр илүү ихийг хийж ажиллах хэрэгцээ шаардлага зайлшгүй байна. Аяны хүрээнд сургууль цэцэрлэгүүд 15.4 сая төгрөгийн хөрөнгө</p>	90

						оруулалтуудыг хийж материаллаг баазаа бүрдүүлж байна. Аянд идэвхтэй манлайлан оролцсон сургууль, анги хамт олныг орон нутгийн хөгжлийн сангаас 4,8 сая төгрөгөөр урамшууллаа.	
3.4	Ахмад багш нарын аймаг, бүсийн зөвлөгөөн зохион байгуулна	6 сая	Зөвлөгөөн зохион байгуулах	-	Зөвлөгөөн зохион байгуулагдаж зөвлөмж гарсан байна	Ахмад багш нарын зөвлөгөөнийг 2022 оны 10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөсөн ч санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдээгүй тул хэрэгжээгүй Хэрэгжилтийн хувь -0	30
3.5	Залуу багш нарын чуулга, уулзалт зохион байгуулна	5 сая	Чуулга уулзалт зохион байгуулах	-	Чуулга уулзалт зохион байгуулагдаж уриалга гарсан байна	Ховд аймгийн Залуу багш нарын холбоотой хамтран залуу багш нарын чуулга уулзалтыг 11 дүгээр сард зохион байгуулах төлөвлөлт хийгдсэн ч санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй тул хэрэгжээгүй. Хэрэгжилтийн хувь-0	30
<i>Бодлогын зорилт: АХТЖҮЧ - 2.1.4, АЗДҮАХ - 2.3.8,</i>							
4	Зорилт -4 “Монгол хэл, бичиг” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх	ОНХС 30 сая	Хэрэгжилтийн хувь	32,5	70	<p>“Монгол хэл, бичиг” дэд хөтөлбөр 2022 онд 46.7 хувьтай хэрэгжсэн байна. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ОНХС-аас 3,5 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлөөс “Үндэсний бичиг үсгээ сурах, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх, дэд хөтөлбөрийг эрчимжүүлэх тухай” албан бичгийг хүргүүлж ЕБС, СӨБ-ын байгууллагаас гэрэлтдэг том хаяг-14, жижиг хаяг-56, орчин бүрдүүлсэн 42, дотор хаягжилт буюу 940 анги танхимын хаягийг монгол бичгээр бичсэн.</p> <p>Жаргалант сумын 13 байгууллага том жижиг хаягтай болсон байна. ЕБС, СӨБ-ын байгууллагын албан хаагчдаас анхан шат-1074, дунд шат-703, ахисан шат 192 буюу 77 хувь нь монгол бичгийн сургалтад хамрагдаж байна. 66 байгууллагын 740 албан хаагчид монгол бичгийн хичээлийг заасан байна. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний хүрээнд Монгол бичгийн хичээлийг /МУГБ Б.Даваадорж/ Ховд ТВ бэлтгэн цахимаар хүргэж байна. Тус хичээлийг Үндэсний бичиг, өв соёл-Олон ястны бахархал цахим хуудсаар түгээсэн. 1-р сургуулийн “Эх хэл бичгийн өргөө” танхимаар дамжуулан Үндэсний бичгээр цахим бичвэр боловсруулах арга зүй” сургалтыг хамтран зохион байгууллаа. Сургалтад 16 сумын ЗДТГ-ын бичиг хэргийн ажилтан, аймгийн ЗДТГ-ын хүрээний 44 байгууллагын 44, нийт 60 хүн хамрагдахаас 46 нь оролцлоо. БШУГ-ын мэргэжилтэн,</p>	86.6

						ажилчид анхан, дунд, гүнзгийрүүлсэн шатны сургалтад бүрэн хамрагдаж суралцаж байна.	
4.1	Хөтөлбөрийг сурталчлах, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах	ОНХС 30 сая	Хэрэгжилтийн хувь	0	70	“Байгууллагын соёл, ёс зүй, хамтын ажиллагааны үр дүнг сайжруулах нь” сэдэвт боловсролын салбарын удирдах ажилтнуудын сургалтад /04.04-05/ “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III” болон “Монгол хэл, бичиг” дэд хөтөлбөр, шалгуурт суурилсан үнэлгээний даалгавар боловсруулах чиглэлээр багийн ажил 5 удаа зохион байгуулав. Нийт 110 хүн оролцлоо. Монголчуудын оюуны соёлын ил уурхай, үнэт өв, тусгаар тогтнолын баталгаа болсон монгол бичгийн гайхамшиг, сурч судлахын учир, ач холбогдлыг таниулах "ӨВЛӨН ДЭЭДЛЭХ ҮНДЭСНИЙ БИЧИГ МИНЬ" лекцийг СУГ-ын мэргэжилтэн Б.Бадамцэцэг соёл, урлагийн салбарын удирдах ажилтнууд, аймгийн төвийн 7 байгууллагын нийт 300 гаруй албан хаагчдад уншиж, үндэсний бичгээ сурахыг уриаллаа. Үндэснийхээ бичиг үсгийг сурах, хэрэглэж хэвшихийг уриалсан “Үндэсний бичиг өв соёлоороо бахархъя” цахим уриалгыг /challenge/ цахимаар түгээлээ. “ҮНЭТ ӨВ, ҮНДЭСНИЙ ДАРХЛАА-ЭХ ХЭЛ МИНЬ” аяныг зохион байгуулж 3500100 төгрөгийг зарцуулсан байна. Хүрсэн түвшин 66,7%	95,3
4,2	Албан байгууллага, аж ахуйн нэгж монгол бичгийн орчин бүрдүүлэх	Үйл ажиллагааны зардал	Орчин бүрдүүлсэн албан байгууллагын хувь	0	80	ЕБС, СӨБ-ын байгууллагаас гэрэлтдэг том хаяг-14, жижиг хаяг-56, орчин бүрдүүлсэн 42, дотор хаяжилт буюу 940 анги танхимын хаягийг монгол бичгээр бичсэн байна.Жаргалант сумын 13 байгууллага том жижиг хаягтай болсон байна. Хүрсэн түвшин 70%	87.5
4.3	Монгол хэл, бичгийн сургалт сурталчилгааны төв байгуулах	8 сая	Төв байгуулсан байх	0	1	Жаргалант сумын 1 дүгээр сургууль ТХБ-2 “Хос бичигтэн-Хосолсон сургалт” дэд төслийн хүрээнд Эх хэл бичгийн өргөөг байгуулав. Хүрсэн түвшин 100%	100
4.4	Насан туршийн боловсрол төв, нэгжээр дамжуулан иргэдэд монгол бичиг заах сургалтыг үе шаттай хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны зардал	Монгол хэлбичгийн сургалтад хамрагдсан төрийн албан хаагчийн хувь	20	90	ЕБС, СӨБ-ын байгууллагын албан хаагчдаас монгол хэл бичгийн анхан шатны сургалтад -1074, дунд шатны сургалтад -703, ахисан шатны сургалтад 192 буюу 77 хувь нь монгол бичгийн сургалтад хамрагдаж байна. Мөн ЕБС-ийн багш нар 66 байгууллагын 740 албан хаагчид монгол бичгийн хичээлийг заасан байна. Нийт төрийн албан хаагчдын 50.2 хувь нь монгол бичгийн сургалтад хамрагдаж байна. 1-р сургуулийн “Эх хэл бичгийн өргөө” танхимаар дамжуулан НТБТ-тэй хамтран	50

						сургуулийнхаа эцэг эх болон иргэдэд сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна. Хүрсэн түвшин 50	
4.5	Монгол хэл, бичгийн зөв бичих дүрэм, журамласан үгийг цахим сайтад байршуулж нийтэд түгээх	Үйл ажиллагааны зардал	Цахим сайтад байршуулсан дүрэм, журамласан үг	0	120	“Үндэсний бичиг, өв соёл-Олон ястны бахархал” цахим хуудсаар дамжуулан монгол бичигтэй холбоотой мэдээ, мэдээлэл, зохион байгуулж буй үйл ажиллагааны явц, хэрэгжилтийг сурталчилж, журамласан дүрэм, үг 120 -ыг сайтад байршуулав. Хүрсэн түвшин 120	100
<i>Бодлогын зорилт: АЗДҮАХ - 2.3.11, 2.3.27,</i>							
5	Зорилт -5 Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулалтыг нэмэгдүүлэх	Төсөл, улсын зардал	СӨБ, ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамралтын хувь	82	83	Ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй 160 сурагч, НТБТ-д 60 /аймгийн төвд-23, сум-37/ хүүхэд, сургуулийн өмнөх боловсролд 17 хүүхэд хамрагдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 71 хувь нь боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна. ХБХ-ийг боловсролын үйлчилгээнд хамруулахдаа ХБХБЭМНХ-н салбар комисс, сургуулийн дэмжлэгийн баг, боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл, эцэг эхтэй хамтран ажиллаж боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлж байна. Мөн эцэг, эх олон нийтийн хандлагыг нэмэгдүүлэх үе шаттай сургалтуудыг зохион байгуулснаар эцэг эх хүүхдээ боловсролын үйлчилгээнд хамруулдаг болж байна.	95
5.1	Сургуулийн багш ажилтанд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн дэмжлэг үзүүлэх, чадваржуулж	Үйл ажиллагааны зардал	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйд суралцсан бага ангийн багшийн хувь	15	30	Японы Хүүхдийг ивээх сантай хамтран 3, 7 дугаар сургуулийн багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бага ангиас дунд ангид шилжин суралцах шилжилтийн хөтөлбөр, сургалтын үйл ажиллагааг дэмжих, арга зүйн үе шаттай сургалтууд зохион байгууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй болон багш нарыг чадваржуулах сургалтад Улаанбаатар хотод 18 багш, аймагт 118 багшийг хамрууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрт илрүүлэг хийх, цогц үйлчилгээ үзүүлэх сургалтад 28 хүн, сургуулиудын дэмжлэгийн багийн гишүүдийг чадваржуулах сургалтад 35 хүн хамрагдаж мэргэжлээ дээшлүүллээ. Сургууль, цэцэрлэгийн дэмжлэгийн багийн гишүүдийг чадваржуулах сургалтыг 2 удаа зохион байгууллаа. Сургалтад дэмжлэгийн багийн 86 хүн сургалтын менежер, эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, багш нар хамрагдлаа. 38 эцэг эх, 19	100

						багшид зөвлөгөө өглөө. Бага ангийн багш нарын 53 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйд суралцлаа. Сургууль, цэцэрлэгийн дэмжлэгийн багийн гишүүдийг чадваржуулах сургалтыг 2 удаа зохион байгууллаа. Сургалтыг БШУЯ, ХНХЯ, БЕГ, ЯХИС, ХБХ-н хөгжлийн ерөнхий газар, эцэг эхийн холбоотой хамтран зохион байгуулсан нь үр дүнтэй байлаа. Сургалтад дэмжлэгийн багийн 86 хүн сургалтын менежер, эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, багш нар хамрагдлаа. ҮИ, Манхан сумын цэцэрлэг, Зэрэг, IX цэцэрлэгийн багш нарт Жайка Start 2 төслийн сургалт зохион байгууллаа. Сургалтад 62 багш хамрагдаж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйд суралцлаа.	
5.2	Насан туршийн боловсролыг хүн амын хэрэгцээнд нийцсэн байдлаар өргөжүүлэх	Улсын төсөв	Дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдагсдын тоо Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	ДХ - 656 СХИ- 5919	ДХ-656 СХИ-6700	Дүйцсэн хөтөлбөрийн сургалтад нийт 694 суралцагч суралцаж байгаагаас 109 суралцагч танхимаар хичээллэж, 5-р ангийг – 31, 9-р ангийг – 83, 12 –р ангийг 107 суралцагч төгсөж зохих шатны боловсрол эзэмшлээ. НТБТ, нэгжүүдээс иргэдийн боловсролыг дэмжих 82 төрлийн сургалтыг 254 удаа зохион байгуулж 7133 иргэнийг хамруулав.	90
<i>Бодлогын зорилт: АЗДҮАХ- 2.3.10</i>							
6	Зорилт -6 "Стандартай Ховд хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх	ОНХС 10 сая	Хөтөлбөрийн г хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Стандартай Ховд хөтөлбөрийн хүрээнд боловсролын байгууллагуудын үйл ажиллагаанд “Чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001:2015” стандартыг 2022-2024 онд нэвтрүүлэх төлөвлөлтийг хийж сургууль, цэцэрлэгүүдийн жил бүрийн гэрээнд тусган ажиллаж байна. Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001:2015” стандартын сургалтад нийт сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтнуудыг хамрууллаа.	50
6.1	Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд чанарын удирдлагын стандартыг нэвтрүүлэх	ОНХС 50 сая	Чанарын удирдлагын стандарт нэвтрүүлсэн сургууль	0	Сургууль-3 Цэцэрлэг-4	Энэ онд Жаргалант сумын 7, Прогресс, ЦАЦС, МБЦС, Үенчийн сургууль, Жаргалант сумын 1,14,16, Буянт сумын цэцэрлэгүүд “Чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001:2015” стандартыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. МБЦС-ийн удирдлагууд стандартыг хэрэгжүүлэх зөвлөх байгууллагын төлөөллөөс зөвлөмж авав	50

			цэцэрлэгийн тоо				
<i>Бодлогын зорилт: АХТЖҮЧ-2.3.5,</i>							
7.	Зорилт -7 Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны зардал	Хэрэгжилтийн хувь	72	75	<p>Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэнд хяналт үнэлгээ хийх нэгдсэн судалгаанд Мөст сумын сургууль сонгогдон нийт 250 эцэг эх, захирал, нийгмийн ажилтан судалгаанд хамрагдлаа. Нэмэлтээр 6 сургуулийн сэтгэлзүйч, нийгмийн ажилтан хамрагдлаа. Бодлогын хэрэгжилтийн үнэлгээний судалгааны дүнгийн мэдээллийг БШУЯ, “Ирээдүйн нээлттэй цонх”, ТББ-ын үнэлгээний багаас цахим уулзалтаар сургууль цэцэрлэгийн захирал, хүүхэд хамгааллын багын гишүүдэд танилцууллаа.</p> <p>Хүүхэд хамгааллын баг сургууль цэцэрлэг бүрд байгуулагдан “Хүүхэд хамгааллын бодлог”-оо батлан хэрэгжүүлж байна. Нийт 2365 сурагчдад хүүхэд хамгааллын бодлогын дагуу үйлчилгээг хүргэж, 86 хүүхдийг бусад байгууллагын үйлчилгээнд холбон зуучиллаа.</p>	90
7.1	Хүүхдийг аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулах	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны тоо Хамрагдалтын хувь	Хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой гомдол 3,	Буурсан байна.	<p>Хүүхдийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх А/53 тоот 16 чиглэл бүхий зөвлөмжийг сургууль, цэцэрлэгт хүргүүлэн тайланг улирлаар авч нэгтгэн ажиллаж байна. Мөн сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн боловсруулсан зөвлөмж контентийг иргэдэд цахимаар хүргэн ажиллаж байна. Ekids.mn сайтын Харилцаа холбооны зохицуулах хороо, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн Сан Хамтран “Цахим орчин хүүхэд хамгаалал” сэдэвт ерөнхий боловсролын сургуулийн сурагч, багш, эцэг эхчүүдэд зориулсан сургалтын материал, гарын авлага, зөвлөмж, ХЭВЛЭМЭЛ ФОСТЕРУУД-ын санг сургуулиудын эцэг эхийн нэгдсэн группэд байршуулж ажиллах чиглэлийг хүргүүллээ. Сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид нийт 47 оролцогчдод “Хүүхэд хамгааллын өнөөгийн байдал анхаарах асуудал” сэдвээр 2 өдрийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтад зочин багшаар СНА-ны тэргүүн Б.Мөнхжаргал “Хүүхэд хамгааллын бодлого анхаарах асуудал” сэдвээр</p>	90

						зөвлөмж өгөв. Прокурорын байгууллагатай хамтран Жаргалант сумын 7-н сургуулийн 9 дүгээр ангийн 150 сурагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт үйл ажиллагааг зохион байгууллаа. 2022 оны 11 сарын байдлаарх тоон судалгаагаар 18 нас хүртэлх насны сэжигтэнээр татагдсан сурагч 27, оюутан 5 хохирогч сурагч, оюутан 33, зөрчлийн хэрэгт холбогдсон 44 сурагч 7 оюутан байна. Хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой 5 гомдол ирснийг хянан шийдвэрлүүлэв.	
7.2	Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд удирдлага арга зүйн дэмжлэг үзүүлэх, тайлагнах	Үйл ажиллагааны зардал	Цэцэрлэг, сургуулийн ХХБ-ын хэрэгжилтийг сайжруулах талаар хийсэн нэгдсэн арга хэмжээний тоо	3	6	7-н сургуулийн /Цэцэг, Манхан, Дарви, Чандмань, Зэрэг, Алтай, МБЦС/ хүүхэд хамгааллын бодлоготой танилцаж зөвлөгөө өглөө. Минжит булган цогцолбор сургуулийн 50 сурагчийг сурган хүмүүжүүлэх арга зүйн хуралд оролцуулж мэдээлэл солилцуулсан. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрхэн хэрэгжүүлэх талаар сургуулийн хүүхэд хамгааллын багуудад албан бичгээр 1 удаа зөвлөмж хүргүүлж, 2 удаагийн цахим сургалтаар арга зүйг түгээсэн. Сум сургуулийн хүүхэд хамгааллын баг нийт давхардсан тоогоор 1800 сурагчдад хүүхэд хамгаалал хүүхдийн эрх, сэтгэлзүйн сургалт тус тус хийсэн.	90
7.3	Хүмүүжлийн эерэг арга зүйг түгээх багийг бэлтгэх багш нарын сургалтад хамруулах	ОУБ Дэлхийн зөн	Бэлтгэсэн сургагч багш Хамрагдсан багш, ажилтан	2 340	20 1800	БШУЯ-наас зохион байгуулсан “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” -ын сургагч багш бэлтгэх сургалтад сургууль бүрээс нэг, нийт 25 багшийг хамруулснаар сургагч багш нар сургууль дээрээ сургалт зохион байгуулж нийт 950 багш хүүхэд хүмүүжлийн эерэг арга зүйн сургалтад хамрагдсан байна. Мөн 4700 эцэг эхчүүдэд хүмүүжлийн эерэг аргын сургалтаа зохион байгуулж нөлөөллийн ажлыг өргөжүүллээ. Цаашид байгууллагын эцэг эхчүүдэд хийхээр төлөвлөгдөн ажиллаж байна.	90
7.4	Анги удирдсан багшаар дамжуулж эцэг эхийн боловсролыг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны зардал	Сургалтад хамрагдсан эцэг, эхийн тоо	246	1000	“Анги удирдсан багш нараар дамжуулан эцэг эхийн боловсролыг дэмжих нь” сургалтын гарын авлага, зөвлөмжийг сургууль бүрд хүргүүлснээр 24 сургуулийн анги удирдсан багш нар зөвлөмж гарын авлагын дагуу сургалт зохион байгуулж 4700 эцэг эхчүүдийг хамруулсан байна. Дарви, Жаргалант сумын 6 дугаар сургуулийн нийгмийн ажилтнууд, хүүхэд хамгааллын мэргэжилтэн УБ хотод сургагч багшаар бэлтгэгдлээ.	90

						Цаст-Алтай сургуулийн багш нарт АУБ ЭЭБ-ыг нэмэгдүүлэх дээшлүүлэх хөтөлбөрийн гарын авлагыг хэрхэн хэрэглэх талаар арга зүйн сургалт хийлээ.	
<i>Бодлогын зорилт: АХТЖҮЧ - 2.1.3, АЗДҮАХ -2.3.4,</i>							
8	Зорилт -8 “Чанартай боловсрол” дэд хөтөлбөр хэрэгжүүлэх	ОНХС 25 сая	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	0	30	“Чанартай боловсрол” дэд хөтөлбөрийг 3 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг хэрэгжүүллээ. БҮТ өөс бүх сургуульд гүйцэтгэлийн үнэлгээг хэрэгжүүлсэн бол хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж аймгийн 9 дүгээр ангийн математикийн хичээлээр 46 бүлгийн 1388 сурагч буюу нийт хүүхдийн 91,9% , 9 дүгээр ангийн монгол хэлний хичээлээр 57 бүлгийн 1496 буюу 95,2%, 5 дугаар ангийн монгол хэл 68 бүлгийн 1956 буюу 95,8%, 5 дугаар ангийн биеийн тамир эрүүл мэндийн 68 бүлгийн 2014 буюу 95,4%, СӨББ-ын ахлах бүлгийн танин мэдэхүйн хөгжлийн түвшний хөгжилөөр шалгалт авсан бөгөөд нийт чанарын үнэлгээний дундаж 53%-тай шалгагдсан нь БҮТ-өөс шалгагдсан үнэлгээтэй ихээхэн дөхөж байна Иймд чанарын үнэлгээний тогтолцоог улам сайжруулж сургалтын чанарыг сайжруулахаар ажиллаж байна. Аймгийн шалгалт нь орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон эцэг эхийн хяналт дор зохион байгуулагддаг.	93.3
8.1	Дэд хөтөлбөр болон орон нутгийн чанарын үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх журмыг нийтэд сурталчлах, мөрдүүлэх	Үйл ажиллагааны зардал	Хөтөлбөр, журмыг сурталчлах, сургалт нөлөөллийн арга хэмжээний тоо	0	3-аас доошгүй	Дэд хөтөлбөр, журмыг хэрэгжүүлэх талаар цэцэрлэг сургуулийн удирдлагуудад чиглэл зөвлөмжийг албан бичгээр өгч, боловсролын удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөний хүрээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөлт, тайлагналтын арга зүйн сургалтыг зохион байгуулав. Мөн 6 сургуулийн хамт олонд хөтөлбөрийн талаар сургалт мэдээлэл хийв. Зохион байгуулсан сургалт нөлөөллийн нэгдсэн арга хэмжээний тоо -3	100
8.2	2-10 дугаар ангийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаа авах, тэргүүний анги, сургуулийг шалгаруулж алдаршуулах	ОНХС 80 сая	Хамрагдалтын хувь гүйцэтгэлийн хувь	97,3% 40,1%	98% 51%	Нэгдсэн хуваарийн дагуу цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхдүүдээс танин мэдэхүйн хөгжлийн түвшингийн, ерөнхий боловсролын 5-р ангийн сурагчдаас эрүүл мэнд, биеийн тамирын, 9-р ангийн сурагчдаас математик, монгол хэлний хичээлийн чанарын судалгаа авлаа. Судалгаанд 24 сургууль, төрийн өмчийн 33 цэцэрлэгийн 6824 хүүхэд хамрагдлаа. Чанарын судалгаанд судлагдахуун бүрээр амжилттай шалгарсан сурагч, багш, анги хамт олон, сургуулийг эхний 3 байраар шалгаруул нийт 19 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа.	90

8.3	Сургалт хөгжлийн цахим платформыг сургуулиудын үйл ажиллагаанд нэвтрүүлэх.	120 сая	Цахим платформ нэвтрүүлсэн сургууль	0	24	Боловсролын салбарын цахим сургалтын орчинг сайжруулах зорилгоор БШУ-ны яамнаас хэрэгжүүлсэн Microsoft-ийн Office 365-ийн А1 лицензийг бүх сургуулиудад өгч, ашиглах зааврын сургалтыг цахим хэлбэрээр 2 удаа зохион байгуулав. Teams программыг ашиглан багш нарын уулзалт, хэлэлцүүлэг сургалтыг зохион байгуулж хэвшив. БШУЯ, БЕГ, БҮТ, БСҮХ-ийн Medle.mn, ESIS.mn цахим платформуудыг ерөнхий боловсролын сургуулиуд үйл ажиллагаандаа ашиглаж байна. Орон нутгийн нэгдсэн платформ үүсгэн нэвтрүүлэхэд зориулж ОНХС-аас 120 сая төгрөгийг батлуулж, хамтран хэрэгжүүлэх байгууллагуудын талаар судалгаа хийж байна. “Дижитал-Ховд аймаг” төслийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх бодлогын хүрээнд ЕБС-д ICT группийн би төлөөлөгч нартай уулзаж хөгжүүлж байгаа платформын мэдээллийг авч санал солилцсон.	90
<i>Бодлогын зорилт: АХТЖҮЧ - 1 ,</i>							
9.	Зорилт -9 “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих	Үйл ажиллагааны зардал	Хамрагдалтын хувь	Багцын үзлэг 85%	90%	Сургууль,цэцэрлэгийн нийт багш ажилчдын 95 % нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, нийт сурагчдын 18957 буюу 95% нь ерөнхий биеийн үзлэгт орсон байна. Ковидын өвчлөлийн болон вакцины мэдээг сургууль цэцэрлэгээс 2 удаа авч анализ хийсэн. Багш, ажилчид бүрэн тунд - 98.2 хувь, III тунд 49.1 хувь, 12-17 насны хүүхдүүдээс 1-р тунд- 106736 буюу 86.9% 2-р тунд- 88209 буюу 71.8% нь хамрагдсан байна. Ковидын бэлэн байдлын сургалтад цэцэрлэгийн аргазүйч 16 сургуулийн 10 нийгмийн ажилтан эмч хамрагдсан Хүрсэн түвшин 90%	93.3

9.1	Гэнэтийн болон онцгой байдлын үед хариу арга хэмжээний бэлэн байдлыг бүрдүүлэх	Улсын төсөв	Гэнэтийн болон онцгой байдлын үед хариу арга хэмжээний бэлэн байдлын төлөвлөгөө тэй сургууль цэцэрлэгийн тоо	Сургууль 25 Цэцэрлэг 33	Сургууль 25 Цэцэрлэг 33	<p>Нийт 25 сургууль 33 цэцэрлэгт гэнэтийн болон онцгой байдлын үед үзүүлэх хариу арга хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангах талаар зөвлөгөө өгч хэрэгжилтийн үнэлгээ хийв. Үнэлгээний явцад гамшиг онцгой байдлын үе гэдэгт цар тахал буюу хөл хорионы нөхцөл байдлыг ойлгож байгаа нь бусад гамшиг онцгой байдлын үед хүүхэд хамгаалал хариу үйлчилгээ дадлага сургуулилт хийх талаар мэргэшүүлэн сургах хэрэгцээ байгаа нь ажиглагдаж байна.</p> <p>Жаргалант сумын 7 сургууль 2 цэцэрлэг, Манхан, Зэрэг сумдын сургууль, цэцэрлэг дотуур байрын гамшгийн эрсдэлийн үнэлгээг Онцгой байдлын газрын мэргэжилтэнтэй хамтран хийлээ. Сургууль, цэцэрлэг, дотуур байрын эрсдэлийн үнэлгээний тайланд үндэслэн ДЗХ ОНХХ-өөс 7,5 сая төгрөгийн санхүүжилтийг 5 байгууллагад олгов.</p>	90
9.2	Эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулах	Үйл ажиллагааны зардал	Хамрагдалтын хувь	Багш ажилчид 85% Сурагчид 75%	Багш ажилчид 90% Сурагчид 85%	<p>Ерөнхий боловсролын сургуулийн 1118 цэцэрлэгийн 627 багш ажилчдыг эрүүл мэндийн нэмэлт үзлэгт хамруулж эрүүл мэндийг дэмжих зардал 24 сургуульд 122180,9 мянга, цэцэрлэгт 42600,0 мянган төгрөгийн зардал тусгагдсан. Эрүүл мэндийн сайдын 145-р тушаалын дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бага ангийн 351, хоол үйлдвэрлэлийн 99, сургуулийн өмнөх боловсролын 575 багш ажилчид хамрагдсан. Нийт сурагчдын 18957 буюу 95% нь ерөнхий биеийн болон амны хөндийн эрүүл мэндийн үзлэгт хамрагдлаа.</p> <p>Хамар залгиур хоолойн үзлэгт бага ангийн 8708 сурагч цэцэрлэгийн 1959 багачууд, томуугийн вакцин хийлгэсэн.</p> <p>Хүрсэн түвшин 92%</p>	100
9.3	Хөдөлгөөн –Эрүүл мэнд аян зохион байгуулах	Үйл ажиллагааны зардал	Арга хэмжээний тоо Хөгжлийн үзүүлэлт	2 52.6	2 55.0	<p>Дэд хөтөлбөрийн аянд 24 сургуулийн 15607 гаруй сурагч, хүүхэд багачууд эх эцэг багш ажилчид хамрагдаж 1130,0 мянган төгрөг, 33 цэцэрлэгийн 5561 хүүхэд багачууд эх эцэг багш ажилтан нар хамрагдаж 16047,98 мянган төгрөгний санхүүжилтийг зарцууллаа.</p>	90

						Энэ аяны хүрээнд 58 сургууль, цэцэрлэг 483 ажил зохион байгуулж, сургуулийн 494, цэцэрлэгийн 111 бүлгийн 14640 сурагч, цэцэрлэгийн 2734 сурагчид хамрагдаж сургууль 648.0 мянга, цэцэрлэг 8 сая орчим санхүүжилт зарцуулжээ. Хөдөлгөөн эрүүл мэнд аяны ажлын үзүүлэлтээр 3 сургууль, 4 цэцэрлэг шалгарч 900,0 мянган төгрөгөөр шагнуулсан байна. Биелэлтийн хувь:100	
<i>Бодлогын зорилт: АХТЖҮЧ - 1, ЗДҮАХ-4-2,</i>							
10	Зорилт-10 “Хариуцлагатай тунгалаг төр” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны зардал	Хэрэгжилти йн хувь	72%	80	2022 оны жилийн байдлаар манай байгууллагад ёс зүйн болон эрх зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагч байхгүй байна. Байгууллагын санхүү төсөл, үйл ажиллагааны нээлттэй байдлыг ханган ажиллаж төсөв санхүүгийн мэдээллийг шилэн дансны хуулийн дагуу нийтэд ил тод мэдээллэн ажиллаж байна. Мөн салбарын нэгдсэн хурал зөвлөгөөн цагтаа эхлэж цагтаа дуусах соёлыг хэвшүүлээд байна.	90
10.1	Цагийн менежментийг чанд мөрдөж, хурал, зөвлөгөөн, сургалт, семинар, хэлэлцүүлгийг товлосон цагт нь эхлүүлж хэвшинэ.	Үйл ажиллагааны зардал	Нийт нэгдсэн хурал, сургалт, арга хэмжээнээс цагтаа эхэлж, цагтаа дууссан арга хэмжээний хувь	90	100	Салбарын хэмжээнд сургалт үйл ажиллагаа цахим болон танхимаар цагтаа эхэлж хэвшсэн. 7 хоногийн Лхагва гаригийн 9 цагт сургууль цэцэрлэгтэй цахим шуурхай уулзалт тогтмол явагддаг. Байгууллагын нэгдсэн хурал Даваа гарагт 8:30 минутад тогтмол хийгдэж хэвшсэн. Алива хурал цуглаан цахим сургалт цагтаа эхэлж хэвшсэн	90
10.2	Төр, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, төрийн үйлчилгээнд олон нийтийн оролцоог	Үйл ажиллагааны зардал	Төр, ИНБ- тай хамтран зохион байгуулсан арга	12	24	ХГБХГ, СУГ, ЭМГ, БОАЖГ, ХХҮГ, Дэлхийн зөн ОУБ, Хүүхдийг ивээх сан, АНУ-ын соёл мэдээллийн төв - 8 байгууллагатай хамтран ажиллах танилцуулах уулзалт зохион байгуулж төлөвлөгөөний төсөл танилцуулав. Байгууллагын хэмжээнд 2022 онд нийт 25 ажил төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хийж хэрэгжүүлсэн байна.	90

	нэмэгдүүлж, нийгмийн эгэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.		хэмжээний тоо				
Бодлогын зорилт. ЗДҮАХ-2-3-5,							
11.1	Сургуулиудын бүтэц, хэв шинжийг орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн оновчтой болгож, төрөлжсөн, гүнзгийрүүлсэн, олон улсын хөтөлбөртэй сургуулиудийг хөгжүүлнэ	Үйл ажиллагааны зардал	Төрөлжсөн, гүнзгийрүүлсэн сургалттай сургуулийн тоо	2	3	Ерөнхий боловсролын 25 сургууль нь дараах бүтэц хэв шинжтэй хичээллэж байна. Үүнд: Цогцолбор-2, гүнзгий сургалттай-2, лаборатори-1, ердийн сургалттай-20 сургууль. Жаргалант сумын ЕБ-ын "Прогресс" сургууль 6, 10 дугаар ангиас англи хэл, математикийн гүнзгийрүүлсэн сургалттай 1, 1 ангийг 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн авч 2022-2023 оны хичээлийн жилд нийт 6-р ангийн 1 бүлэгт-24, 7-р ангийн 1 бүлэгт-25, 9 дүгээр ангийн 1 бүлэгт-24, 10 дугаар ангийн 1 бүлэгт-18 нийт 4 бүлэгт 91 хүүхэд хичээллүүлж байна. Ховд их сургуулийн дэргэдэх ахлах сургууль 10-12 дугаар ангид математик, хими, физик, биологи, гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай хөтөлбөр хэрэгжүүлж ажиллаж байна. БШУЯ-ны сайдын тушаалаар ЦАЦС-ыг Кембрижийн хөтөлбөрөөр сургалт явуулахаар шийдвэрлэсэн. Кембрижийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх суруулиудтай танилцах БШУЯ, Кембрижийн хөтөлбөрийн багийн ажлын хэсэг ЦАЦС, Манхан, Зэрэг сумын сургуулийн үйл ажиллагаатай танилцсан. Булган сумын 1, МБЦС-ыг төрөлжсөн, гүнзгийрүүлсэн сургалттай болгон хөгжүүлэх судалгаа хийгдэж байна. Тонг төхөөрөмжийн хангалтыг сайжруулж цаашид төрөлжсөн сургалттай сургуулийг бий болгох чиглэлээр судалгааг хийж байна.	80
11.2	ЦАЦС-д олон улсын Кембрижийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангана.	Үйл ажиллагааны зардал	Эрх зүйн орчин бүрдсэн байна.	0	1	Кембрижийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх суруулиудтай танилцах БШУЯ, Кембрижийн хөтөлбөрийн багийн ажлын хэсэг ЦАЦС, Манхан, Зэрэг сумын сургуулийн үйл ажиллагаатай танилцав.	70
11.3	Сургуулиудыг орон нутгийн хөгжлийн онцлог, төлөвлөлттэй нийцүүлэн, төрөлжсөн гүнзгийрүүлсэн	Үйл ажиллагааны зардал	Шинээр гүнзгийрүүлсэн, төрөлжсөн сургалтын	0	1	Ерөнхий боловсролын 25 сургууль нь дараах бүтэц хэв шинжтэй хичээллэж байна. Үүнд: Цогцолбор-2, гүнзгий сургалттай-2, лаборатори-1, ердийн сургалттай-20 сургууль. Жаргалант сумын ЕБ-ын "Прогресс" сургууль 6, 10 дугаар ангиас англи хэл, математикийн гүнзгийрүүлсэн сургалттай 1, 1	90

	сургалттай, цогцолбор сургуулийн хэв шинжээр хөгжүүлэх.		хөтөлбрөөр хичээллүүлэх сургуулийн тоо			ангийг 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн авч 2022-2023 оны хичээлийн жилд нийт 6-р ангийн 1 бүлэгт-24, 7-р ангийн 1 бүлэгт-25, 9 дүгээр ангийн 1 бүлэгт-24 , 10 дугаар ангийн 1 бүлэгт-18 нийт 4 бүлэгт 91 хүүхэд хичээллүүлж байна. Ховд их сургуулийн дэргэдэх ахлах сургууль 10-12 дугаар ангид математик, хими, физик, биологи, гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай хөтөлбөр хэрэгжүүлж ажиллаж байна. БШУЯ-ны сайдын тушаалаар ЦАЦС-ыг Кембрижийн хөтөлбөрөөр сургалт явуулахаар шийдвэрлэсэн. Кембрижийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх суруулиудтай танилцах БШУЯ, Кембрижийн хөтөлбөрийн багийн ажлын хэсэг ЦАЦС, Зэрэг сумын сургуулийн үйл ажиллагаатай танилцав. Булган сумын 1, МБЦС-ыг төрөлжсөн, гүнзгийрүүлсэн сургалттай болгон хөгжүүлэх судалгаа хийгдэж байна. Тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулж цаашид төрөлжсөн сургалттай сургуулийг бий болгох чиглэлээр судалгааг хийж байна.	
Хоёр:Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт: АХТЖҮЧ - 2.1.6, АЗДҮАХ - 2.3.27,							
1.	Зорилт -1 Салбарын байгууллагын мэргэжлийн хүний нөөцийг чадваржуулах	Улсын төсөв	Сургалтад хамрагдсан багшийн тоо,	сургалтанд 1379 багш хамрагдсан	Сургалтад хамрагдсан багшийн тоо нэмэгдсэн байна.	Төрийн өмчийн 25, 41 цэцэрлэгийн хүний нөөцийг чадваржуулахын тулд 14 мэргэжилтэн 4375 багш удирдах болон бусад ажилтнуудад цахим танхим хосолсон сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 11 сургуулийн 375 багшийн оролцсон судалгаат хичээлийг зохион байгуулж бүх судлагдахуунаар аймгийн төвийн 7 сургуулийн мэргэжлийн багш нарыг багш солилцоонд хамруулж бие биенээсээ туршлага арга зүйг харилцан сурах болмжийг бий болгож 548 багшийн хичээлд сууж 2222 багш менежер нарт зөвлөгөө өгч ажилласан байна. Элсэлтийн ерөнхий шалгалтад 12 дугаар ангийн сурагчдыг амжилттай бэлтгэхийн тулд 10 хичээлийн судлагдахуунаар 70 гаруй удаагийн сорилыг авч давхардсан тоогоор 14770 гаруй сурагчийг хамруулан шалгаж шалгалтын сэдэвт гарсан алдаа, тухайн даалгаврыг хийж гүйцэтгэх зөвлөмжийг өгч ажилласан байна.	90
1.1	Үндсэн сургалтад хамруулах	Улсын төсөв	Хамрагдах багшийн хамралтын хувь	50	70	2022 оны эхний жилийн багш нарын болон эхний, 5 10 жилийн удирдах ажилтны сургалт 6 дугаар сард цахимаар явагдаж эхний жилийн сургалтад хамрагдах 98 багш, удирдах ажилтнаас 67, буюу 68,4% нь, 5, 10 жилийн сургалтад хамрагдах удирдах ажилтан 19-өөс 16 буюу 84,2% нь хамрагдсан байна. Сургалтад 100% хамруулахаар байсан боловч тухайн багш нар нь эрүүл мэндийн, шилжсэн, ажлаас	90

						гарсан, сургалтын мэдээлэл мэйл хаягт ирээгүй зэргээс шалтгаалсан байна. Багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын 5 жилийн багшийн сургалтад 55, 10 жилийнхэд 49 багш хамрагдсан байна.	
1.2	Орон нутгийн сургалт зохион байгуулах	Улсын төсөв, төсөл хөтөлбөр	Хамрагдсан багшийн тоо	0 0	1367	Боловсролын удирдлага, багш нарыг чадваржуулах цахим танхим хосолсон сургалтад давхардсан тоогоор 4375 хүн хамрагдсан байна. Үүнд жишээ нь Орон нутгийн багш нарыг багш нарыг чадваржуулах цахим контент ээлжит хичээл бэлтгэхэд туслах зорилгоор БМТТ-өөс 5 зөвлөх багшийг урьж 10 судлагдахууны 183 багш нарыг хамруулж чадваржуулсан. Математикийн багш нарт 2 удаагийн онлайн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 165 хүнийг хамрууллаа. Мэдээлэл зүйн багш нарыг танхимаар 1 удаа, онлайнаар 1 удаа сургалт зохион байгуулж 83 хүнийг хамрууллаа. Судлагдахуун бүрийн мэргэжлийн хөгжлийн хөгжлийн бүлгийг идэвхтэй ажиллуулж зохион байгуулалтаар хангаж зөвлөх багш нар манлайлан, зөвлөж ажиллах зохион байгуулалтад оруулж ажиллуулж байна. Мөн аймгийн 2022 оны элсэлтийн ерөнхий шалгалтад сурагчдаа амжилттай бэлтгэсэн 20 багш 2 сургуулийн бүх 10 судлагдахууны багш нарт арга зүйн зөвлөгөө өгч сурагчдаас ЭЕШ-ийн сэдвээр шалгалт авч алдсан сэдвээр давтлага өгч сурагчдын эцэг эхэд зөвлөгөө өгч ажиллаж байна. Хүүхэд хамгааллын чиглэлээр сургуулийн нийгмийн ажилтан багш, удирдлага сэтгэл зүйч сурагч эцэг эх 2866 хүнд сургалт зохион байгуулсан байна. СӨББ-ын багш удирдах ажилтан, арга зүйч нарын сургалтыг 7 хоног бүрийн Мягмар баасан гарагт тогтмол зохион байгуулж байна. Бага ангийн хувьд бага ангийн хичээл сургалтын үр дүнг үнэлэх дүгнэх шалгуурыг хэрэглэх арга зүй цахим сургалтыг зохион байгуулж байна.	90
Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт: АХТЖҮЧ - 2.1.6,							
2	Зорилт -2 Мэргэжил арга зүйн дэмжлэг өгөх	Үйл ажиллагааны зардал	Багшийн тоо /давхардсан тоогоор/	98 удаагийн цахим зөвлөмжийг 3100 багшид хүргэсэн	Эрэлтэд нийцсэн мэргэжил арга зүйн дэмжлэгийг нийт багш	Үүссэн нөхцөлд нийцүүлэн сургалтын хөтөлбөрийн тасалдлыг арилгахад ашиглаж болох сургалтын дэвшилтэд арга зүй, сургалтад мэдээллийн технологийг ашиглах, даалгаварт нэгдсэн шинжилгээ хийх арга зүйн сургалтыг нийт багш, удирдлагуудад зохион байгуулав. Жаргалант сумын 16-н цэцэрлэг, хөдөөгийн Манхан, Зэрэг, сумдын цэцэрлэгт багаар ажиллаж, Жаргалант сумын ЕБ-ын	90

					нарт хүргэсэн байна.	сургуульд Байгалийн ухаан, нийгмийн ухаан, Дизайн технологи, Математик монгол хэл, хөгжим, биеийн тамирын мэргэжлийн багш нарын багш солилцоог хийж харилцан арга зүй, туршлагаа солилцож хамтран ажилласан. 2022-2023 хичээлийн жилд бүх сургууль цэцэрлэгийн багш нарын 548 хичээлд сууж цахимаар удирдах ажилтан болон багш нартай судлагдахуун хариуцсан мэргэжилтнүүд болон удирдлагууд арга зүйн зөвлөгөөг тогмтол өгч хэвшсэн байна.	
2.1	Багш нарын хичээл үйл ажиллагаанд ажиглалт хийж, зөвлөгөө өгөх	Үйл ажиллагааны зардал	Ажиглалт хийсэн хичээлийн цагийн тоо Зөвлөгөө өгсөн багшийн тоо/давхардсан тоогоор/	289 3172	1200 3500	БШУГ-ын мэргэжилтнүүд 2022 онд 16 сумын сургууль, 25 цэцэрлэгт ажиллаж 548 цагийн хичээлд сууж, 146 цагийн хичээлийн сайжруулалт хийн давхардсан тоогоор 2222 багш, ажилтан, удирдлагуудад сургалтын технологи, менежментийн талаар зөвлөмж өглөө. Мөн мэргэжлийн бүлгүүдийн цахим уулзалтуудыг хуваарийн дагуу зохион байгуулж давхардсан тоогоор 2585 багш, ажилтанд мэргэжил арга зүйн зөвлөмж өгсөн байна.	90
2.2	Цахим хичээлийн сан бүрдүүлэх	Үйл ажиллагааны зардал	Хичээлийн тоо	45	50	Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэж байгаа хими, биологи, эрүүл мэнд, монгол хэл бичиг, уран зохиолын багш нарт Багшийн тус бүтээлч аяныг өрнүүлж онлайн 16+12 цагийн сургалтыг зохион байгууллаа. Medle.mn сайтад Математик-Монгол хэл бага дунд, газарзүй, иргэний ёс зүйн боловсрол, түүх, уран зохиол үндэсний бичиг, Эрүүл мэнд зэрэг 7 төрийн 9 судлагдахууны цахим контент, ээлжит хичээл бэлтгэн 66 хичээл шалгаран байршиж, 197 хичээл эрхээ авч нийт 263 хичээл байршихаар байгаа нь 406 хичээлийн 64,8% болж байна.	90
2.3	Судалгаат хичээл зохион байгуулах	Үйл ажиллагааны зардал	Судалгаат хичээл зохион байгуулсан багшийн тоо	0	24	7 судлагдахууны хичээлээр судалгаат хичээлийг зохион байгуулж багш нартайгаа мэргэжилтнүүд хамтран оролцож харилцан туршлага судалж хамтран ажиллаж байна. Судалгаат хичээлд мэргэжилтнүүд 375 багштай хамтран зохион байгуулж байна. Жишээ нь судалгаат хичээлийг хими, эрүүл мэнд биологи, монгол хэл уран зохиолын судлагдахуунаар 20 удаа зохион байгуулагдаж нийт давхардсан тоогоор 200 багш ажиглалт хэлэлцүүлэгт оролцсон.	90

2.4	Сурган хүмүүжүүлэх илтгэлийн 2-р шатны шалгаруулалтыг зохион байгуулах	Үйл ажиллагааны зардал	Илтгэл хэлэлцүүлсэн багшийн тоо	48	58	<p>Үндэсний эрдэм шинжилгээний хурлыг БСҮХ-ээс 2021-2022 оны хичээлийн жилд “Багш нарын мэргэжлийн өсөлтөд ахмад багш нарын оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвтэйгээр 4 дүгээр сарын 7-8-ны өдрүүдэд 55 дахь жилдээ зохион байгууллаа. Багш нарын судалгаа, шинжилгээний ур чадварыг дэмжих, эрдэм судлалын ажлын үр дүнг сургалтын үйл ажиллагаатай уялдуулах, тэдний сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, багш нар ажлын байран дээрээ хөгжих боломж, хамтын ажиллагааг дэмжих зорилго бүхий эрдэм шинжилгээний хурлаар нийслэлийн 9 дүүрэг, 21 аймаг, сумаас шалгарсан 30 илтгэлээ 92 багш, удирдах ажилтан 2 өдрийн турш хэлэлцүүлэн, судалгааны үр дүнгээ хуваалцаж, бие биенээсээ суралцлаа. Уг үндэсний эрдэм шинжилгээний цахим хуралд Жаргалант сумын 2 дугаар сургуулийн багш нар илтгэлээ амжилттай хэлэлцүүллээ. Хүрсэн түвшин 54</p>	90
Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт: АЗДҮАХ - 2.3.4, 2.3.6,							
3	Зорилт -3 Сургалтын чанарыг сайжруулах	Үйл ажиллагааны зардал	Сурлагын чанарын дундаж оноо	40,1	45	<p>БҮТ-ийн баталсан удирдамжийн дагуу “Чанарын үнэлгээ”-г 2022 оны 10 дугаар сард 24 сургуулийн давхардсан тоогоор 16566 суралцагч, 20 судлагдахуунаар 145 шалгалт өгч 69,8 оноогоор үнэлэгдсэн нь улсын дундаж /72,5/-аас 2,7-оор, аймгуудын дундаж /71.7/-аас 1,9-ээр бага байна. Гүйцэтгэлийн үнэлгээг шалгалт авч хийхээс гадна багш нарын талаар санал асуулга авсан. Үүнд эцэг эх асран хамгаалагч-15454 оролцсон нь 99,9%, суралцагч-9395 оролцсон нь 96,8%, 1042 багшийг үнэлсэн захирлын тоо /давхардсан/ 994 оролцсон нь 95,39%, багш 1039 нь 99,7%, сургалтын менежер 1030 нь 98,8%, заах аргын нэгдлийн ахлагч 1023 нь 98,2%, нийгмийн ажилтан 985 нь 94,5% оролцоотой санал асуулгад оролцсон. Үүнд гүнзгийрүүлсэн сургалттай Прогресс сургууль 73,6%, лаборатори 1 дүгээр сургууль 72,1%-тай, ердийн 22 сургууль-69,3%-тай шалгагдсан бол аймгийн төвийн сургуулиуд /7 сургууль/-70,8%, хөдөөгийн сургууль /17 сургууль/-69%-тай үнэлэгдсэн. Үнэлгээ асуулгаа хамгийн өндөр хувьтай шалгагдсан Цаст-Алтай</p>	93,7

						цогцолбор -75,2%-тай бол хамгийн бага үнэлгээтэй мөст сумын сургууль-64%-тай шалгадсан. Аймгуудын дундаж оноо 71,7%-аас дээш үнэлэгдсэн 7 сургууль, 17 сургууль доош үнэлэгдсэн. Бичгийн шалгалтын үнэлгээ улсад-51,1%, аймгуудын дундаж-48,9% тай байгаа бол манай аймгийн хувьд 48,3%-тай байгаа нь улсаас -2,8%, аймгуудаас 0,3%-аар бага байна. Аймгийн сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээ дунджаас доогуур байгаад дүгнэлт хийж ирэх хичээлийн жилд илүү анхаарч ажиллахаар байна.	
3.1	ЭЕШ-ын бэлтгэлийн явцын сорилыг сар бүр авч, зөвлөмж боловсруулан багш нарт хүргэх	Үйл ажиллагааны зардал	ЭЕШ дундаж оноо	522,6	534	<p>ЭЕШ-ын бэлтгэлийн төлөвлөгөөг хичээлийн жилийн эхэнд гарган нийт сургуулиудад хүргэж мэргэжил, арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа. Энэ хүрээнд 2022 оны эхний хагаст ЭЕШ-тай 10 хичээлээр 4-6 явцын сорил, нэгдсэн сорил-1, хөндлөнгийн үнэлгээний байгууллагын сорилыг 1 удаа авч даалгавар гүйцэтгэлд шинжилгээ хийн зөвлөмж хүргүүлж ажиллалаа. ЭЕШ-д энэ жилийн төгсөгч 1057, өмнөх онуудын 125 төгсөгч нийт 1182 хүүхэд шалгуулав. Давхардсан тоогоор 2444 сурагч шалгалт өгч урьдчилсан байдлаар 39,2%-ийн дундаж гүйцэтгэлтэй байна.</p> <p>Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэж 10 хичээлээр аймгийн хэмжээний сорил авч нэгтгэлийг гаргаж сургууль бүрт хүргүүлэн тухайн сэдвийн хүрээнд зөвлөмж өгч ажиллаж байна. Жишээ нь математикийн хичээлээр 7 удаагийн шалгалтыг зохион байгуулсан бол давхардсан тоогоор химийн сорилд 3384 сурагч хамрагдаж дундаж гүйцэтгэл 28.1% -тай байна. Судлагдахуун бүрийн сорил бүрийн дүнг нэгтгэж даалгавар бүрээр шинжилгээ хийх нөхцөл бүрдүүлсэн эхсэлийн динамик хүснэгт үүсгэн хүргүүлж ажилласан. Энэ хичээлийн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж 510,3 тай шалгагдаж гүйцэтгэл 95,6% байна.</p>	95,6
3.2	Бага боловсролын багш нарыг чадваржуулах баг байгуулж төлөвлөгөө гарган ажиллах	Үйл ажиллагааны зардал	Багийн төлөвлөгөө ний хэрэгжилт	0	100	Бага ангийн багш нарыг чадваржуулах төлөвлөгөө гарган I-Ү ангийн мэргэжлийн бүлгээр дамжуулан багш нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Зөвлөх, тэргүүлэх багш нартайгаа хамтран багш нарт сургалт зохион байгуулж зөвлөгөө өглөө. Цахим хичээл и-контент боловсруулах сургалтад 87 багш, 13 сургалтын менежер хамрагдлаа. Сургалтыг Tend.mn багш Түвшинбаяр зохион байгууллаа.	100

						<p>“Интерактив ажлын хуудас боловсруулах, хосолсон сургалтын аргаар байгалийн ухааны хичээлийг төлөвлөх арга зүй” сургалтад 24 багш хамрагдлаа. “Бага ангийн хичээл сургалтын үр дүнг үнэлэх дүгнэх шалгуурыг хэрэглэх арга зүй” цахим 283 багш, танхимын сургалтад 24 сургалтын менежер, 24 багш хамрагдлаа. Medle.mn -д цахим хичээл байршуулах талаар Б.Алимаа багшийн цахим сургалтад сургалтын менежер, багш нараа хамрууллаа. Сургалтад 56 багш хамрагдаж зөвлөгөө авлаа. Хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуур, хэрэглэх зөвлөмж номыг багш нартайгаа хамтран судалж “Бага боловсролын монгол хэлний хичээлийн үнэлгээ” facebook хаягаар бага ангийн сургалтын менежер, багш нарт Даваа, Пүрэв гарагт БМДИ-ийн арга зүйч Одсүрэн багшаар зөвлөгөө өгүүлж хамтран ажиллаж байна. “Явцын үнэлгээний өгөгдөлд суурилан бага ангийн сурагчдын математик, монгол хэлний хичээлийн суурь чадварыг хөгжүүлэх арга зүй”-г хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах үйл ажиллагааны хүрээнд 24 сургуулийн 72 багшийн хичээлд сууж 330 багшид зөвлөгөө өгч сургалт зохион байгууллаа. Мэргэжлийн бүлгийн багийн төлөвлөгөөнд тусгасан ажлуудаа 100 хувь гүйцэтгэсэн.</p>	
3.3	СӨБ-ын хүүхдийн чадварын судалгаа хийх	Үйл ажиллагааны зардал	Хүүхдийн хөгжлийн үзүүлэлт	68,7	72	<p>Цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхдийн хөгжлийн түвшин тогтоох шалгалтыг 2022 оны 05 дугаар сарын 16-19-ний өдрүүдэд Жаргалант сумын цэцэрлэгийн арга зүйч, хөгжмийн багш, бэлтгэл бүлгийн багш нартай хамтран зохион байгууллаа. Энэ хүрээнд төрийн өмчийн 33 цэцэрлэгийн 51 бүлгийн 995 хүүхдээс танин мэдэхүйн, бие бялдар, оюун ухааны хөгжлийн сорил авч дүнг нэгтгэхэд аймгийн хэмжээнд 74,8 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдлээ</p>	90
3.4	Туршлага солилцох ажлын үр дүнг сайжруулах	Үйл ажиллагааны зардал	Ажлын байрны солилцоо хөтөлбөрт хамрагдсан багш, ажлтны тоо	49	55	<p>Булган сумын 1, Мижит булган цогцолбор сургуулийн сургалтын менежерүүд Жаргалант сумын 1, 7, Прогресс сургуулийн менежерүүдийн ажлын байрны үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах арга хэмжээнд оролцов. Жаргалант сумын 8, 15 дугаар цэцэрлэг, Дөргөн, Мянгад, Манхан сумын цэцэрлэгийн бүлгийн багш нар ажлын 5 хоногт багш солилцоо хөтөлбөрт хамрагдлаа. Үүнд 25 багш, 2 арга зүйч арга туршлагаа солилцон ажиллав. Нийт 33 багш ажилтан ажлын байрны туршлага судлах арга хэмжээнд хамрагдсан байна.</p>	90

						Багш солилцоонд хими, биологи, монгол хэл бие тамир, хөгжмийн Жаргалант сумын 7 сургуулийн 35 багш оролцов.	
3.5	Багш, сурагчдын олимпиадыг зохион байгуулах	Улсын зардал	Хамрагдвал зохих багш, сурагчийн хамралтын хувь	0	100	БШУЯ-аас ирүүлсэн удирдамжийн дагуу мэргэжлийн хичээлийн олимпиадын 2-ын давааны шалгаруулалтыг зохион байгуулав. Олимпиадад 8 хичээлээр сурагчдын 19 төрөлд 535 сурагч, багшийн 9 төрөлд 291 багш оролцлоо. Олимпиадыг “Алтайн зам” ХК 5 сая төгрөгөөр ивээн тэтгэж, түүхийн олимпиадыг МУГБ Х.Чагдаагийн, физикийн олимпиадыг МУГБ Д.Гунаажавын нэрэмжит болгон зохион байгууллаа. Оролцвол зохих 846 багш, сурагчдаас 826 нь оролцож, хамралтын хувь 97,6 байна. Улсын математикийн 58-р олимпиадын 2-ийн даваанд бага ангийн 42, дунд ангийн 41 нийт 83 багш өрсөлдсөн.	97,6
3.6	Улсын олимпиадад багш сурагчдыг оролцуулах	Улсын төсөв ОНХС	Багш, сурагчийн тоо	29	29	Олимпиадын 2-ын даваанд тэргүүлсэн 28 багш, сурагчид улсын уралдаанд оролцсоноос ЦАЦС-ийн мэдээллийн технологийн багш Д.Баасанжав 2-р байранд шалгарч мөнгөн медаль хүртэв. Монголын түүхийн олимпиадад 7-р сургуулийн Д.Төмөрбаатар тусгай байр, мөн ОХУ-ын Элчин Сайдын Яам, БШУЯ-ны хамтарсан Орос хэлний баруун бүсийн олимпиадад 2 багш, 5 сурагч цахимаар оролцож Булган 1 дүгээр сургуулийн орос хэлний багш Д.Еркегүл, Ховд сумын сургуулийн сурагч А. Еркегүл нар 2 ба 3 дугаар байранд шалгарч ОХУ-д тэтгэлгээр сурч, мэргэжил дээшлүүлэхээр боллоо. Улсын олимпиадад нийт 30 багш, сурагчид оролцов.	100
3.7	Монголын түүх, зан заншил, эх оронч үзэл төлөвшлийг бүр шатны боловсролын суралцагчдад олгох	Үйл ажиллагааны зардал	Арга хэмжээний тоо Хэрэгжилтийн хувь	0	3 100	Жаргалант сумын 1 дүгээр цэцэрлэг, 3 дугаар цэцэрлэг, Булган, Мянгад, Дөргөн, Дарви, Зэрэг сумдын цэцэрлэг дээр ёс заншлын өргөөг өөрсдийн нөөц хөрөнгөөр байгуулж, цэцэрлэгийн ахлах бэлтгэл бүлгийн хүүхдэд мэндлэх хүндлэх ёс, орон нутгийн онцлог, ёс заншил хувцас зэрэг уламжлалт тоглоомыг таниулах, сургах, хамтран бүтээх тоглоомын аргачлал боловсруулан төсөлт үйл ажиллагааг зохион байгуулж байна. Суурь боловсролын ёс зүй, түүх, газарзүйн хичээлийн хөтөлбөрт орон нутгийн иргэдийн түүх, ёс заншлыг судлах агуулгыг тусган хэрэгжүүлж байна. “Монгол бахархал” аяныг 11 сарын 1-нээс 30-ны хооронд ажилттай зохион байгууллаа. Аянд СӨБ, ЕБС, МУИС-ийн Ховд дахь салбар сургууль, Хөгжил политехник коллеж нийт 60	100

						байгууллагын 718 бүлгийн 17600 гаруй хүүхэд багачууд, оюутан сурагчид, багш, ажилтнууд оролцож, төрт ёсны үнэт өв, үндэсний уламжлал, Эзэн богд Чингис хааны суу алдар, аугаа их түүхэн үйл хэргийг сурвалжлан судлах, алдаршуулан мөнхжүүлэх, монголоороо бахархах жүжигчилсэн тоглолт, дуу, шүлэг, постер, видео контентууд хийж, уг бүтээлүүдээрээ дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх 596 үйл ажиллагааг Багшийн хөгжил- Ховд аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар цахим хаягаар түгээн дэлгэрүүллээ.	
3.8	6 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ хийх	Үйл ажиллагааны зардал	Хамралтын хувь	20	100	“Сургуульд хүүхдийг амжилттай бэлтгэх нь” сэдэвт хэлэлцүүлгийг Жаргалант сумын 14 дүгээр цэцэрлэгтэй хамтран 2022 оны 04 дүгээр сарын 06 ны өдөр зохион байгууллаа. Энэхүү хэлэлцүүлэгт бага ангийн багш, сургалтын менежер, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш нарыг төлөөлөл бүхий 90 гаруй хүн оролцож, санал бодлоо солилцов. 6 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын судалгааг БҮТ-ийн удирдамжийн дагуу 2022 оны 9 дүгээр сард зохион байгууллаа. Сургуульд бэлтгэгдсэн байдлын судалгаанд 24 сургуулийн 66 бүлгийн 2169 сурагч сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх үнэлгээнд хамрагдлаа. Сургуульд бэлтгэгдсэн байдалд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох асуулга судалгаанд 7 сургуулийн 22 багш, 300 эцэг эх, 31 цэцэрлэгийн 31 эрхлэгч, 31 арга зүйч, 259 багш хамрагдлаа. Судалгааны материалд сайжруулах санал, тайлан бичиж БҮТ-д хүргүүллээ.	100
3.9	Ээлжит хичээлийн цахим контент боловсруулах	Үйл ажиллагааны зардал	Контентийн тоо	0	409	Цахим хичээл и-контент боловсруулах арга зүйн сургалтад 5 дугаар сард 87 багш, 13 сургалтын менежерийг хамрууллаа. Нийт 409 цахим контент боловсруулах хуваарийг сургууль бүрд анги, хичээлээр төрөлжүүлэн гаргаж хэрэгжилтэд зөвлөмж өгч ажиллалаа. Ээлжит хичээлийн цахим контент боловсруулах арга зүйгээр БШУЯ-ны дэргэдэх мэдээлэл технологийн төвийн Ээлжит хичээлийн цахим контент боловсруулах багийн зөвлөх 5 багшийг 10 дугаар сард урьж Физик, Монгол хэл, хэл бичиг, уран зохиол, газарзүй, дизайн технологи, Математик, биологи, хөгжим, нийгэм судлалын хичээлийн 180 гаруй багшид сургалтыг амжилттай зохион байгуулж багш нарын 406 хичээл medle.mn д байршуулахаас 66 хичээл эрх авч байршигдаж, 197 ээлжит хичээл эрх авч боловсруулалтын шатандаа явж	70

						нийтдээ 263 ээлжит хичээл байршихаар байна. Энэ нь нийт хичээлийн 64,8% байршуулагдаад байна.	
Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт: АХТЖҮЧ -2.1.4, 2.1.8, 2.1.9 АЗДҮАХ -2.3.12-19, 2.3.21, 2.3.22, 2.3.25							
4	Зорилт 4 Сургалтын орчныг сайжруулах	Улс, ОНХС, төсөл 7128,3 сая	Засвар, өргөтгөл хийсэн цэцэрлэг, сургуулийн тоо Тоног төхөөрөмж ийн шинэчлэл хийсэн байгууллаг ын тоо	11 15	8 29	Засвар, өргөтгөл хийсэн цэцэрлэг, сургуулийн тоо -8 Тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн байгууллагын тоо -39 /15 сургууль гал тогооны тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн, улсын төсвийн эх үүсвэрээр 24 сургууль 1,3 тэрбум төгрөгөөр цахим танхим байгуулсан./	96,4
4.1.	Шинээр барих барилга	Улсын төсөв 28 тэрбум 615 сая	Шинээр барьж эхлүүлэх барилга	5	8 /Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, Багш хөгжлийн төв, Дуут, Манханы дотуур байр, Мөнххайрхан сургуулийн барилга, Булган сум, Жаргалант сумын Бичигт, Алагтолгой багийн цэцэрлэг/	Улсын төсвийн хөрөнгөөр 2022-2024 онд хэрэгжих Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Ховд, Жаргалант сум, 12 дугаар баг, Малчны хороолол/- Жаргалант Сумын ИТХ хурлаар 2022 оны газрын төлөвлөгөөнд тусгуулан газрын асуудал шийдэгдсэн. Гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажлын газар шорооны ажил хийгдэж байна. 2022 онд 200 сая төгрөг батлагдсан. Гүйцэтгэгч Баганат орд ХХК Гэрээний дүн 4.801,926,241 хэрэгжих хугацаа 2022-05-11 2023-10-04. Нийт ажлын гүйцэтгэл 5% - Багшийн хөгжлийн төвийн барилга /Ховд, Жаргалант сум/- Газар шийдэгдсэн шинэ суурьшлын бүсэд. Барилга угсралтын ажлын 1-р давхрын гадна дотор өрлөг, 2-р давхрын хэв хашмал, хучилтын 1-р үеийн арматурчлал, хэв хашмалын тэгшилгээний ажлууд хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл-37%. Гүйцэтгэгч Би эм жи юу ХХК гэрээний дүн-2.716,913,272 төгрөг. хэрэгжих хугацаа 2022-04-15 2023-08-01. - Дотуур байрны барилга, 150 ор /Ховд, Манхан сум, Төгрөг гол баг/- Газар бэлэн, Кадастар зурагт оруулсан. Барилга угсралтын ажлын 2-р давхрын хучилтын ажил хийгдэж, 3-р давхрын багананы хэв хашмал хийгдсэн. 2022 онд 800 сая төгрөг батлагдсан. Илүү гүйцэтгэлтэй угсралтын ажил хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл-40%. Гүйцэтгэгч Ховд шинэ асар	90

						<p>ХХК.Гэрээний дүн 3.135,202,843 төгрөг. Хэрэгжих хугацаа 2022-03-24 2023-08-25</p> <p>-Сургуулийн барилга, 160 суудал /Ховд, Мөнххайрхан сум/- Газар бэлэн, Зураг төсөв Жаргалант хийц компани хийлгээд бэлэн болсон.Гэрээ байгуулсан барилга ажил эхлээгүй.</p> <p>- Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Ховд, Дуут сум/- Газар бэлэн, Зураг төсөв Алтайн газрын хүч компаниар хийлгээд бэлэн болсон. 30*15 м харьцаатай 2 давхар зураг хийгдсэн. Барилга угсралтын ажлын 2-р давхрын цутгалтын ажил хийгдсэн. 2022 онд батлагдсан хөрөнгөнд угсралтын ажил гүйцэтгээд ажил зогсч байна. Нийт ажлын гүйцэтгэл 40%.</p> <p>- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Ховд, Булган сум, Баянсудал баг/- Газар бэлэн, Зураг төсөв Жаргалант хийц компаниар хийлгээд бэлэн болсон. Барилга угсралтын ажлын 2-р давхрын дамнуруу, багананы хэв хашмалын угсралт, арматурчлалын ажил хийгдэж байна. Нийт ажлын гүйцэтгэл 30%.</p> <p>-Цэцэрлэгийн барилга, 150 ор /Ховд, Жаргалант сум, Бичигт баг/- Жаргалант Сумын ИТХ хурлаар 2022 оны газрын төлөвлөгөөнд тусгуулан газрын асуудал шийдэгдсэн. Барилга угсралтын ажлын дотор заслын шавардлага, цахилгаан, дээвэр, цонх суулгах ажлууд хийгдэж байна. 2022 онд 800 сая төгрөг батлагдсан. Илүү гүйцэтгэлтэй угсралтын ажил гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 50%. Гүйцэтгэгч Түмдэлгэрэх ХХК. Гэрээний дүн 2.800,597,693 төгрөг. Хэрэгжих хугацаа 2022-05-02 2023-10-24.</p> <p>-Цэцэрлэгийн барилга, 75 ор /Ховд, Жаргалант сум, Алагтолгой баг/- Жаргалант Сумын ИТХ хурлаар 2022 оны газрын төлөвлөгөөнд тусгуулан газрын асуудал шийдэгдсэн. Барилга угсралтын ажлын дотор заслын элсэн шавардлага, гадна шавардлага, цахилгаан, дээврийн ажлууд хийгдэж байна. 2022 онд 800 сая төгрөг тусгагдсан. Ажлын гүйцэтгэл 50%. Гүйцэтгэгч Бүтээмж тауэр ХХК. Гэрээний дүн 1,909,833,223 төгрөг. Хэрэгжих хугацаа 2022-04-11 2023-08-20 Дээрх ажлууд тухайн онд хэрэгжих ажлын төлөвлөгөөг 90% гүйцэтгэлтэй хангасан.</p>	
4.2	Сургууль, цэцэрлэгийн барилгын өргөтгөл их засвар хийх	Улсын төсөв-500 сая Орон нутгийн төсөв-682 сая	Сургууль цэцэрлэгийн тоо	6	8 байгууллага/ Булган, Мөст, Мөнхайрхан	- Цэцэрлэгийн барилгын их засвар /Ховд, Булган сум/- Барилгын их засварын ажлын дээвэр, гадна фасадны ажлыг гүйцэтгэж дууссан. Их засварын ажлын гадна сайдинг, хаалга,	

					Зэрэг Жаргалантын 3-р цэцэрлэг, Дөргөн сургууль, Эрдэнэбүрэн, Үенчийн дотуур байр/	цонх, дээврийн ажлууд хийгдсэн. Материалын үнийн өсөлтийн улмаас ажил түр зогссон ажил эхлээгүй. Гүйцэтгэл-50%. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Үенч, Эрдэнэбүрэн сумдын дотуур байрны засвар, Дөргөн сумын сургууль, дотуур байрны сантехник засвар, Зэрэг сумын цэцэрлэгийн барилга засвар, Жаргалант 3 дугаар цэцэрлэг, Мөст, Мөнххайрхан сумдын цэцэрлэгийн барилга дээвэр засварын ажлууд бүрэн хийгдсэн.	90
4.3	Сургалтын кабинетын тоног төхөөрөмжийг шинэчлэх	ОНХС, 8 сая	Шинэ тоног төхөөрөмж нийлүүлсэн кабинетын тоо	Математик-25, физик-13, Хими-16, Дизайн технологи-13, Биологи-16, Гадаад хэлний лингафон-2.	2-р сургуулийн орос хэлний кабинет байгуулах	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Жаргалант сумын 2 дугаар сургуулийн Орос хэлний кабинет 8,0 сая.төг тоног төхөөрөмжөөр тохижуулсан. БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар Мянгад сумын ЕБС 6 нэр төрлийн 53,7 сая.төг өртөгтэй мэдээлэл зүйн кабинетын тоног төхөөрөмжөөр хангагдсан.	100
4.4	Нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох	Улс, ОНХС, төсөл	Сургууль, цэцэрлэгийн тоо	11 суруулийн хичээлийн байр, 7 дотуур байр, 25 цэцэрлэг	7 сургуулийн хичээлийн байр, 7 дотуур байр, 7 цэцэрлэг	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 7 сумын сургууль цэцэрлэг, дотуур байрын ариун цэврийн байгууламжийг шийдвэрлэхээр ажиллаж байна. Үүнд: 1 дүгээр ээлжийн Алтай, Булган, Үенч, Дуут сумдын ариун цэврийн байгууламж гүйцэтгэл 95 % тай улсын комисс ажиллаж үүрэг даалгавар өгсөн. 2 дугаар ээлжийн /Мөст, Мөнххайрхан, Цэцэг/ сумдын ариун цэврийн байгууламж ажлын гүйцэтгэл 100 % гүйцэтгэлтэй улсын комисс ажиллаж хүлээн авсан. 3, 4 ээлжийн төслөөр дараагийн үлдсэн сумдад 2023 онд хийхээр төлөвлөгдөж байна.	95
4.5	Ерөнхий боловсролын дотуур байр, цэцэрлэгүүдийн хүүхдийн зөөлөн эдлэл, тоглоом, тавилгыг шинэчлэх	185 сая ОНХС, төсөл	Сургууль, цэцэрлэгийн тоо	Зөөлөн эдлэл 19 цэцэрлэг дотуур байр 1, тоглоом - 4 цэцэрлэгт	15 цэцэрлэгийн тоглоом, зөөлөн, хатуу эдлэл, 10 сургуулийн дотуур байрны хатуу, зөөлөн эдлэл шинэчлэх	Аймгийн хөрөнгө оруулалтаар 100,0 сая.төг төсөвт өртөгтэй цэцэрлэгийн хүүхдийн зөөлөн эдлэл-670 ширхэг, тоглоом наадгай-32 багц ангийн тоглоом 19 цэцэрлэгт нийлүүлэгдсэн. ЕБС-ийн дотуур байрны хатуу зөөлөн эдлэл-85,0 сая.төгрөгөөр 75 шкаф 5 сургуульд, 300 хүүхдийн зөөлөн эдлэл 6 сургуульд тус тус хувиарлахаар байна., сумдын орон нутгийн хөгжлийн сангаас 8 цэцэрлэгт нийт 86,0 сая.төг төсөвт өртөгтэй сургалтын хэрэглэгдэхүүн тоглоом наадгай нийлүүлэх арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэн ажиллав.	100

4.6	Сургуулиудын гал тогооны ширээ сандал, тоног төхөөрөмжийг шинэчлэх	35 сая ОНХС Улсын төсвийн 90 сая	Сургуулийн гал тогооны шинэчлэл хийсэн сургууль	Мөст, Дуут, Цаст-алтай, Үенч, Цэцэг, Дарви сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж шинэчилсэн	Ховд сумын сургуулийн гал тогооны 150 хүүхдийн ширээ сандал шинэчлэх, Жаргалант сумын 1,7, Цаст-алтай сургуулийн гал тогооны тоног төхөөрөмж шинэчлэх	<p>-Алтай сумын ЕБС гал тогоонд БШУЯ-наас 1,2, хоолны тогоо зэрэг 15 нэр төрлийн 27,0 сая төгрөгийн өртөгтэй гал тогооны ТоТө авсан.</p> <p>-Булган сумын МБЦС 1,2 хоолны тогоо, 6 ширэмт, цахилгаан пийшин, бэлтгэлийн ширээ БШУЯ -наас олгосон.</p> <p>-Мөст сумын ЕБС Аймгийн хөрөнгө оруулалтаар 27,8 сая.төг гал тогооны ТоТө авсан.</p> <p>-Мөнххайрхан сумын ЕБС БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 11,8 сая.төг гал тогооны ТоТө авсан.</p> <p>-Чандмань сумын ЕБС БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 7,1 сая.төг гал тогооны ТоТө авсан.</p> <p>-Мянгад суманд БШУЯ 20,0 сая.төг ТоТө өгсөн үлдсэн тоног төхөөрөмжийг сумын ОНХС шийдвэрлэсэн.</p> <p>- Эрдэнэбүрэн суманд БШУЯ 13,0 сая.төг 1,2-р хоолны тогоо зэрэг ТоТө өгсөн.</p> <p>- Жаргалант 1, 7 дугаар сургууль сумын ОНХС-аас тус бүр 30,0 сая.төгрөгний тоног төхөөрөмж хүлээн авсан.</p> <p>-Ховд сум БШУЯ-наас гал тогооны ТоТө авсан.</p> <p>Буянт, Манхан, Зэрэг, Үенч, Жаргалант 6 дугаар сургуульд Боловсролын ерөнхий газарт хүсэлт тавьж гол 11 төрлийн нийт 84,1 сая.төг өртөгтэй гал тогооны тоног төхөөржөөр хангасан.</p> <p>-Сумын ОНХ сангаар 12 суманд 24 нэр төрлийн 478,3 сая.төг өртөгтэй гал тогоо, бусад тавилга тоног төхөөрөмж авч хэрэгжүүлж байна.</p> <p>Нийт 15 сургуулийн хоолны газрын тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэв. Сургуулиуд гал тогооны тоног төхөөрөмжтэй болсоноор үдийн хоол хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой болж хүүхдэд очих хоолны амт чанар сайжирсан.</p>	100
4.7	Сурагчдыг сурах бичгээр бүрэн хангах, номын сангийн үйл ажиллагааг сайжруулах	Үйл ажиллагааны зардал	Сурах бичгийн хангалтын хувь, Шаардлага хангасан номын сангийн тоо	Бага анги-98,3% Дунд, ахлах-82,7 ЕБС-ын номын сангийн тоо 24	99% 84% ЕБС-ын номын сангийн тоо 25	2022-2023 оны хичээлийн жилд бага боловсролын БЕГ-ийн хуваарьт I-V ангийн 114,411,030 /нэг зуун арван дөрвөн сая дөрвөн зуун арван нэгэн мянга гучин/ төгрөгний үнэ бүхий 33 нэр төрлийн 37,036 ширхэг, нэмэлтээр 2,063,950 /хоёр сая жаран гурван мянга есөн зуун тавин/ төгрөгний үнэ бүхий 9 нэр төрлийн 500 ширхэг, VI-XII ангийн 71,376,791.8 /далан нэгэн сая гурван зуун далан зургаан мянга долоон зуун ерөн нэг төгрөг найман мөнгө/ төгрөгний үнэ бүхий 105 нэр төрлийн 20040	100

						<p>ширхэг сурах бичгээр хүүхдүүдийг сургуулийн номын сангаар дамжуулан ашиглуулахаар хангалт хийсэн.</p> <p>2022-2023 оны хичээлийн жилд 25 ерөнхий боловсролын сургуульд нийт 7323 багцын 213 нэр төрлийн 114312 ширхэг 320,558,251 төгрөгийн үнэ бүхий сурах бичгийг сургуулийн номын фондод ашиглуулж байгааг сурагч эцэг эхчүүдэд танилцуулан сургуулийн номын сангаар дамжуулан 5513 багц номыг 99,117,400 төгрөгөөр түрээслэн 38,810,700 мянган төгрөгийг БШУЯ-ны дансанд төвлөрүүлэн 60,306,700 төгрөгийн үлдэгдэлтэйгээр ашиглуулж байна.</p> <p>Энэ хичээлийн жилийн бага ангийн сурах бичгийн хангалтын хувь 98.7, дунд ахлах ангийн сурах бичгийн хангалтын хувь 83.%, түрээсийн сурах бичгийн ном түрээсэлсэн хувь 78%-тай байна. 12 дугаар ангийн сурагчид сурах бичгээ түрээслэн хэрэглэхгүй байгаагаас болон бусад ангиудын хүүхдүүд номын санд байгаа түрээсийн сурах бичгээс бага тоотой байгаагаас ихэвчлэн шалтгаалж түрээсийн сурах бичиг 100 ашиглагдахгүй байна. Сурах бичгээс гадна төсөл хөтөлбөр болон аймагт хуваарилагдсан ном гарын авлагыг тухай бүрд нь татан авалт хийж хуваарилалт хийнэ сургууль цэцэрлэгт түгээж байна.</p>	
Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт: АХТЖҮЧ - 2.1.5, 2.1.9, АЗДҮАХ - 2.3.30-19,							
5	Зорилт-5 Хяналт шинжилгээ, зөвлөх үйлчилгээ үзүүлэх	Үйл ажиллагааны зардал	Зөвлөх үйлчилгээ үзүүлсэн сургууль цэцэрлэгий н тоо Үнэлгээ хийсэн сургууль цэцэрлэгий н тоо	СӨБ-33 ЕБС-25	СӨБ-33 ЕБС-25	<p>БШУГ-ын мэргэжилтнүүд 15 сургууль, 21 цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцан, сургуулийн удирдлага, багш, ажилтнуудад зөвлөн туслах үйлчилгээ хүргэв.</p> <p>Сургуулийн өмнөх боловсролын 41 байгууллагын багш, арга зүйч эрхлэгч нарт сургалт, зөвлөн туслах үйл ажиллагааг байнга хийж, аймгийн төвийн 16 цэцэрлэгийн үйл ажиллагаанд бусад судлагдахууны болон хариуцсан мэргэжилтэн байнга хамтран ажиллаж хичээлд сууж ажиглалт хийж зөвлөн тусалж ажиллаж байна. ЕБС-ийн судлагдахуун хариуцсан мэргэжилтнүүд өөрийн судлагдахуунаар багш солилцоо болон судалгаат хичээлийг байнга зохион байгуулж байна.</p>	81,7

5.1	IX, XII ангийн суралцагчдад мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлэх	Үйл ажиллагааны зардал	Мэргэжил сурталчлах аянд оролцсон сурагч, мэргэжлийн холбоодын тоо	Сурагч 2500, мэргэжлийн холбоодын тоо 5	Сурагч 2850, мэргэжлийн холбоодын тоо 10	Сургууль бүр мэргэжил сонголтын удирдлага арга зүйн багийг 8-10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж 8-11 дүгээр ангийн 5812 сурагчдад сургалт зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулав. Цаашид мэргэжил сонголтын үйл ажиллагааг 6 дугаар ангиас эхлэн системтэйгээр зохион байгуулах бодлого баримтлан ажиллаж байна. Мөн ХХҮГ, ГБХЗХГ, ХоИС, Политехник коллеж НТБ төв, БШУГ-ын хамтарсан баг Жаргалант сумын 7 сургуулийн 1200, Манхан сумын 250 сурагчдад мэдээлэл хийж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүллээ. Мөн сургууль бүрийг багц гарын авлагаар ханган ажиллалаа. ХНХЯ, БШУЯ, ЗДТГ, ГБХЗХГ-тай хамтран “Ирээдүйн эзэд” нэгдсэн сургалтыг амжилттай зохион байгууллаа. Тус сургалт үйл ажиллагаанд Жаргалант сумын 12 дугаар ангийн 350 гаруй сурагч хамрагдлаа. Политехник коллежийн үйл ажиллагаатай танилцах “Найзаа урья” үйл ажиллагаанд Жаргалант сумын 7 сургуулийн 9 дүгээр ангийн 370 сурагч оролцож сургуулийн дадлага, лабораториудын үйл ажиллагаатай танилцлаа. Мэрнэжил сонгол аяныг ХХҮГ-ын санхүүжилтээр нийт 10-12 дугаар ангийн 1374 сурагчидад сум бүрээр амжилттай зохион байгууллаа. Мөн намрын ээлжит мэргэжил сурталчлах өдөрлөгөөр нийт 450 сурагчидад мэргэжил сонголтод миний чадвар өөрийгөө олох нь сургалтыг зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 362 удаагийн үйл ажиллагаанд 10348 сурагч 3607 эцэг эх оролцсон бол цахимаар 50 зонтент бэлтгэн хүргэсэн байна. АМЧБ олгох үндэсний сургалтад НТБТ багш, Ц.Урангэрэл, мэрэгжилтэн О.Өлзийсайхан нар бэлтгэгдлээ. Аймгийн хэмжээнд АМЧБО ажлын хэсэг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр БШУГ-ын ахлах мэргэжилтэнгээр ахлуулан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.	90
5.2	Цэцэрлэг сургуулийн өөрийн үнэлгээнд үндэслэн хөндлөнгийн үнэлгээ хийх	Үйл ажиллагааны зардал	Сургууль цэцэрлэгийн тоо	0	СӨБ-8 ЕБС-5	Журмын дагуу төрийн өмчийн бүх сургууль, цэцэрлэгүүдийн өөрийн үнэлгээний тайланг 10 дугаар сард авч бүх сургууль цэцэрлэгийн өөрийн үнэлгээний тайлантай танилцаж дүн шинжилгээ хийж ажиллаж байна.	50
5.3	Боловсролын тухай хууль, дүрэм журмыг олон нийтэд мэдээлэх сурталчлах	Үйл ажиллагааны зардал	Иргэдийн тоо	Танхимаар-256, Цахимаар-2500 нийт 2756	4000	Боловсролын хөгжлийн бодлого, хууль дүрэм, журмын талаарх мэдээллийг 363 иргэнд танхимаар зохион байгуулж, боловсролын хуулийн шинэчлэл, БШУЯ, БЕГ, БҮТ-өөс ирүүлсэн журам, чиглэлүүдийг цахимаар сурталчлан, давхардсан тоогоор 3800 иргэдэд хүргэв.	100

5.4	Дотуур байрны өөрийн үнэлгээ хийх	Үйл ажиллагааны зардал	Дотуур байрны тоо Үнэлгээний хувь	18 74,1	18 80	2022 оны эхний хагас жилийн байдлаар ерөнхий боловсролын 18 сургуулийн дотуур байрны стандартын өөрийн үнэлгээний дүн 75% байгаа нь өмнөх оныхоос 1,15% ийн өсөлттэй байна. Мөн хамгийн өндөр үнэлгээтэй нь 85%, хамгийн бага нь 59,8% байна.	90
5.5	Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд боловсролын мэдээллийн системийг нэвтрүүлж, эцэг эх, багш, суралцагчдын цахимаар мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх	Үйл ажиллагааны зардал	Цахим мэдээлэл нэвтрүүлсэн сургууль, цэцэрлэгийн тоо	Сургууль 11 Цэцэрлэг-24	Сургууль 25 Цэцэрлэг -33	<p>Боловсролын салбарын мэдээллийн системд үүсгэсэн модулиуд болох Багш, суралцагч ажилтан, байгууллагын мэдээлэл, төгсөлт дэвшилт, төгсөгчийн баримт бичиг, цахим журнал, хүний нөөц, эцэг эх, элсэлтийн модулиудыг нэвтрүүлэн хэрэгжүүлж ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 67 байгууллагын статистик мэдээ болон бусад мэдээ мэдээллээр цахим санг жил бүр тухайн мэдээ гаргах бүрд үүсгэн хадгалж байгаагаас гадна боловсролын удирдлагын мэдээллийн системд оруулсан мэдээлэл хичээлийн жил бүрээр хадгалагдаж тусгай эрхээр орж авах боломжтой юм.</p> <p>Боловсролын салбарын мэдээллийн системийн модуль цахим журналыг манай аймгийн хувьд 3 дахь жилдээ амжилттай ашиглаж байна.</p> <p>Цахим журналын хөтлөлтийг өдөр бүр хийж хаврын төгсөлтөөр журналаа хааж төгсөлт дэвшилтийг хийдэг тул бүх сургуулиуд цахим журналаа хааж төгсөлт дэвшилтэй хийгээд байна. Харин насан туршийн хоёр боловсрол төв цаасан журналаа ашиглаж байна. Мөн цахим сургуульд 10 дугаар ангийн 543 сурагч сонгох хичээлд хамрагдаж байна. Мөн багш сурагч medle.mn-д байршуулсан цахим контентийг багш сурагч сургалт хичээлдээ ашиглаж байгаа бөгөөд мэдлээд хандсан багшийн хувь 33%-тай байна.</p>	90
5.6	Сургалтын байгууллагын орчны стандарт, аюулгүй байдлын үнэлгээ хийх	Үйл ажиллагааны зардал	Эрсдэлийн үнэлгээ буурсан цэцэрлэг сургуулийн тоо	эрсдэлтэй СӨБ-21 ЕБС-25	Буурсан байна.	<p>Ерөнхий боловсролын сургуулийн гадаад болон дотоод орчны эрсдэлийн үнэлгээний судалгаагаар 29,5% -ийн эрсдэлтэй байна. Хамгийн өндөр эрсдэлтэй сургууль 43,5% үнэлгээтэй байна.</p> <p>Нийт 33 цэцэрлэгийн үнэлгээ хийхэд бага эрсдэлтэй нь 96%, хамгийн их эрдэлтэй нь 55,1%, дундаж үзүүлэлт 63% байна. Дотуур байрын стандартын үнэлгээ 75% болж өмнөх үнэлгээнээс 1,15% өссөн үзүүлэлттэй байна. Хуучин барилга байгууламжид гэрэлтүүлэг, дээвэр сангийн асуудал эрсдэлтэй</p>	70

						байгаа бол шинээр барьсан байгууламжид шал цонх дээвэр, цахилгаан гэсэн үзүүлэлтүүд өндөр эрсдэлтэй байна.	
Гурав: Хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг зорилт: АХТЖҮЧ - 2.1.7, 2.1.2, АЗДҮАХ - 2.3.5, 2.3.26							
1	Зорилт: 1 Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны зардал	Хэрэгжилтийн хувь	98	100	Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд 8 зорилт, арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллалаа.	96,3
1.1	Тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар дүгнэлт гаргаж мэдээллийг нэгтгэн тайлагнах	Үйл ажиллагааны зардал	Сургууль, цэцэрлэгийн тоо	12	2	Жаргалант сумын цэцэрлэгүүдээс шинээр бүлэг нээж ажиллуулах, тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлт БШУГ-т ирүүлсний дагуу БШУГ-ын даргын 2022 оны 02 дугаар сарын 14 өдрийн А/03 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг бүлэг эхлүүлэхтэй холбоотой ирүүлсэн хүсэлт, холбогдох материалууд нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 353 дугаар тушаалаар баталсан "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага/ -ыг хангаж байгаа эсэх болон шинэ бүлэг эхлүүлэх танхимын багтаамж, дотоод орчин, үйл ажиллагааны төлөвлөлтүүд нь холбогдох хууль журмуудын шаардлагад нийцэж байгаа байдалтай нэг бүрчлэн танилцаж төрийн өмчийн 3 цэцэрлэгт 11 бүлэг, хувийн өмчийн 1 цэцэрлэгт 2 бүлэг нийт 4 цэцэрлэгт 13 бүлэг нэмэх, хувийн өмчийн нэг цэцэрлэгийн тусгай зөвшөөрөл сунгах дүгнэлт гарган БШУГ-т танилцуулан ЗДТГ-т албан тоотойр байгууллагаас бичиг хүргүүлэн захирамжийг хүлээн авсан.	90
1.2	Орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойргийг тогтоох	Үйл ажиллагааны зардал	Гүйцэтгэл	Тогтоож мөрдүүлж эхэлсэн	Мөрдүүлж хэрэгжүүлэх	2022-2023 оны хичээлийн жилд сургуульд элсэх элсэлтийг цахимаар зохион байгуулсан бөгөөд 2020 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/24 тоот тушаалыг мөрдүүлж ажиллаж байна. Хамран сургах тойргийг тогтоохдоо сумдын хувьд сумын хилийн дээсээр тогтоож аймгийн төвийн хувьд тухайн сургуулийн ойролцоох орон сууц, гудамжаар хуваарилан элсэлт болон хамран сургахад мөрдөж ажиллаж байна. Дээрх хамран сургах тойргийг 2023 онд дахин шинэчлэн, сайжруулах шаардлага байгаа тул барилга байгууламжийн судалгаа, план зургийг гаргаж ажиллахаар бэлтгэж байна.	90
1.3	Боловсролын тайлан мэдээллийг хууль тогтоомжид заасан	Үйл ажиллагааны зардал	Статистик тайлан мэдээний тоо, хувь	115 100	115 100	Боловсролын салбарын 25-н сургуулийн захиргааны болон албан ёсны 21 маягт, сургуулийн өмнөх боловсролын 42 байгууллагын 10 маягтаар мэдээллийг нэгж байгууллагаас гарган авч нэгтгэн хүргүүлэхээс гадна бусад дээд шатны	100

	журмын дагуу нэгтгэн тайлагнах					байгууллагаас бодлого тодорхойлоход шаардагдах судалгаа, тоон мэдээлэл, асуулга, бүхий 30 гаруй нэмэлт ажлыг хийж гүйцэтгэлээ.	
1.4	Орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийг сонгон шалгаруулах	Үйл ажиллагааны зардал	Сонгон шалгаруулалт зарлаж шийдвэрлэсэн ажлын байрны тоо	11	3	Аймгийн хэмжээнд 25 сургууль, 33 төрийн өмчийн өмчийн цэцэрлэгээс түр үүрэг гүйцэтгэгч ажиллаж байсан 2 сургууль, 2 цэцэрлэгт сонгон шалгаруулалт зарласан бөгөөд Дуут сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрлэгч, Булган сумын 1 дүгээр сургуулийн захирлын ажлын байрны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт 2022 оны 2 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан. Манхан сумын цэцэрлэгийн эрхлэгч тэтгэвэртээ гарч ажлын байрны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт 2022 оны 3 дугаар сарын 25-ний өдөр зохион байгуулсан. Энэ хагас жилийн хугацаанд 2 сургуулийн захирал, 2 цэцэрлэгийн эрхлэгчийн ажлын байрны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт болж 1 сургуулийн захирал, 2 цэцэрлэгийн эрхлэгчийн ажлын байрны сул орон тоог нөхөж ажилласан. Өөрийн хүсэлтээр “Цаст-Алтай” цогцолбор сургуулийн захирал ажлаа хүлээлгэн өгсөн, дуут сумын ЕБ-ын сургуулийн захирал түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсныг ажлын байрны сонгон шалгаруулалтыг хуулийн хүрээнд 11 дүгээр сард зарлаж явуулснаар 2 сургуулийн захиралд 1, 1 хүн тэнцэж дээд шатны байгууллагаас ирэх шийдвэрийг хүлээж түр орлон гүйцэтгэгч нар ажиллаж байна .	100
1.5	Багш суралцагчийн амжилтыг үнэлж шагнаж урамшуулах	Үйл ажиллагааны зардал	Багш суралцагчийн тоо	415	415	Жаргалант сумын ЕБ-ын 6 дугаар сургуулийн газарзүйн багш Н.Нарандуламын Засгийн газрын шагнал “Боловсролын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэгт тухайн сургуулиас ирсэн цахим холбогдох материалтай танилцаж БСМС-ээр хянаж хүсэлтийг дэмжиж БШУЯ-нд цахимаар хүргүүлсэн. Хагас жилийн хугацаанд цахимаар салбарын байгууллагаас шагналын 1 хүсэлт ирүүлснийг уламжилж шийдвэрлүүлсэн. Дэлхийн болон монголын багш нарын баярын өдрөөр шагнуулахаар БШУЯ-ны тэргүүний ажилтан тэмдэгт БШУГ-т ЕБС-иас 33, цэцэрлэгээс-5, БШУЯ-ны жуухад ЕБС-иас-45, СӨББ-аас-27, бусад байгууллагаас жуух-21 тэргүүн-8 нийтдээ 139 материал ирснийг журмын дагуу хянаж илгээснээс Тэргүүн-9, Жуух-61 олгогдож багш, ажилтан шагнууллаа. Мөн БШУГ-ын 3-н тэмдэгээр Ахлах багшид-26, Багшийн алдарт-74, Арга зүйч багшид-102, аймгийн бусад шагналд-122 тодорхойлолт ирнийг	100

						шийдвэрлэж ахлах багш-26, багшийн алдар-30, Арга зүйч багш-84, аймгийн шагналд-45 хүн шагнагдаж багш нарын баярын өдрөөр 463 тодорхойлолт ирнээс 255 багш ажилтан шагнал авсан байна.	
1.6	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байуулах	Үйл ажиллагааны зардал	Хэрэгжилтийн хувь	55	70	Боловсролын салбарт хэрэгжиж буй 3 үндэсний хөтөлбөрийн 12 заалтыг хяналтад авч ажилласан 74 %-ийн хэрэгжилттэй байна Хүрсэн түвшин 74 %	100
1.7	Үдийн хоол хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, зөвлөн туслах	Үйл ажиллагааны зардал	Хяналт зөвлөгөө өгсөн сургуулийн тоо	24	24	Энэ хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын 24 сургуульд I-V ангид нийт 10398 сурагч "Үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж байна. Нийт 24 сургуулиас 15 сургууль өөрсдөө 9 сургууль тендер буюу аж ахуйн нэгжтэй гэрээ хийн хамтран үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлж байна Хөдөөгийн 17 сургуулийн "Үдийн хоол" хөтөлбөрт 6 асуулга бүхий бичвэр тайлан дээр баримтын шинжилгээ хийсэн. Жаргалант сумын 7 сургууль, 4 аж ахуйн хоол үйлдвэрлэлтэй 2 удаа мэргэжлийн хяналтын газар болон Жаргалант сумын ЗДТГ-ын төлөөлөлтэй хамтарсан хяналт үнэлгээ хийв. 5 дахь өдөр бүр 24 сургуулиас үдийн хоолны хяналтын хуудас авч байна. Өдөр бүр боловсролын мэдээллийн системд 24 сургууль 43 цэцэрлэг бүр мэдээлэл оруулж буйд хяналт хийж зөвлөгөө өгсөн. 22 сургуульд цахимаар зөвлөгөө өгсөн. Хүрсэн түвшин 24	100
1.8	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хяналтад авах	Үйл ажиллагааны зардал	Хэрэгжилтийн хувь	95	100	Засгийн газрын 17 тогтоол, ИТХ-ын 6 тогтоолыг хяналтдаа авч, БШУ-ны сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнэж үзэхэд 91,3%-тай байна. Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.	90
Хуулиар олгосон чиг үүрэг зорилт: АХТЖҮЧ - 2.1.2, 2.1.7, АЗДҮАХ - 2.3.5, 2.3.26							
1	Зорилт 1 Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны зардал	Хэрэгжилтийн хувь	100	100		96,3
1.1	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулах	Үйл ажиллагааны зардал	Арга хэмжээний тоо	3	4	Ховд аймгийн багшийн ёс зүйн зөвлөлийг Аймгийн засаг даргын 2021 оны 10 сарын 19-ны өдрийн А/596 тоот тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан. Ёс зүйн зөвлөл нийтдээ 5 удаа хуралдаж 10 өргөдөл гомдлыг шийдвэрлээд байна. Ёс зүйн жилийн хүрээнд сургууль цэцэрлэгийн ёс зүйн зөвлөлийн гишүүдийг цахим сургалтад хамруулж ёс зүйн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллалаа.	100

						<p>Зөвлөлийн гишүүн Д.Батнасан Жаргалант сумын 5, 13 дугаар цэцэрлэг, Булган сумын Минжит Булган, Жаргалант сумын 2, 6-р сургуульд ёс зүйн сургалтыг танхимаар зохион байгуулж аймгийн нийт ёс зүйн зөвлөлийн гишүүд 136 хүнийг хамруулан онлайн сургалтыг 1 удаа зохион байгууллаа.</p> <p>Сургууль бүрд ёс зүйн нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажиллаж байна. Сургууль, цэцэрлэг болон төрийн бус байгууллага, холбоод хамтран "School police", "БИ-БИД найзыгаа дүү нараа дээрэлхэхгүй", "Бид дээрэлхэхгүй-Хүүхдийн ялгаатай байдлыг хайрлаж хүндэтгэе" \challenge\-г нийгмийн сүлжээнд байршуулж, Алтайн сумын сургуульд анги удирдсан багш нарын дунд "Бид хамгаална" хэлэлцүүлэгийн цагтай болсон сайн туршлага байна. Мөн "Эерэг харилцаа-Дотно инээмсэглэл" аянд сургуулийнхаа 750 хүүхдийг нэгтгэсэн Үенч сумын сургуулийн туршлага зэрэг 20 гаруй арга хэмжээнд нийт багш, сурагч, ажилтаны 90 хувийг хамруулсан байна. Мөн үе тэнгийн дээрэлхэлтийн судалгаа авч дээрэлхэлт үйлдэж болзошгүй сурагчдад зөвлөгөө өгч ажилласан байна.</p>	
1.2	Байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивын бүрдүүлэх	Үйл ажиллагааны зардал	Бүрдүүлэлтийн хувь	100	100	<p>2022 оны байдлаар нийт 400 албан бичиг ирж, 382 албан бичиг явуулсан байна. Даргын тушаал 93 гарсанаас А тушаал 75, Б тушаал-18 гарсан байна. Байгууллагад нийт 80 өргөдөл ирснээс гэрчилгээ нөхөн авах-7 тэтгэмж хүсэх-19, байгууллагын ажилтан чөлөө хүссэн-9, салбарын байгууллагын ажилтан чөлөө хүссэн-9, гомдол гаргасан-12, ажил хүссэн-8, санал хүсэлт-13, өргөдөл гаргах-3 байна. Албан бичгийн хэвлэмэл А5 хуудас-300, А4-150, 150 ширхэг даргын тушаалын хуудас хэвлүүлсэн байна.</p>	100
1.3	Салбарын статистик мэдээллийг нэгтгэн хэрэглэгчдэд хүргэх	Үйл ажиллагааны зардал	Салбарын тоон мэдээллийн гарсан эмхэтгэлийн тоо	2	2	<p>Салбарын тоон мэдээллийг нэгтгэн гаргаж дээд шатны байгууллага болох БШУЯ-нд хүргүүлэхийн зэрэгцээ албан хэрэгцээнд болон аймаг орон нутгийн удирдах албан тушаалтнуудад албан хэрэгцээнд өгч мэдээллээр хангаж ажиллаж байна.</p> <p>Сургууль, цэцэрлэгийн 2022-2023 оны хичээлийн жилийн статистик тоон мэдээллээр гарын авлага эмхтгэлийг 11 сард гаргасан.</p> <p>Мөн байгууллагын цахим хуудсанд тодорхой мэдээллийг байршуулан ажиллаж байна. Мөн боловсролын салбарын тоон мэдээллийн нэгтгэлийг аймгийн статистикийн хэлтэст өгч</p>	100

						<p>нэгдсэн байдлаар хэрэглэгчдийн хэрэгцээнд гарын авлага болгон гаргаж тархаалтыг хийж байна.</p> <p>Мэргэжилтнүүд, удирдах албан тушаалтан болон дээд шатны байгууллагыг салбарын тоон мэдээллээр нээлттэй хангаж ажиллаж байна.</p> <p>Аймгийн статистикийн хэлтэст 2021-2022 оны хичээлийн жилийн боловсролын салбарын тоон мэдээллийг нэгтгэлийг танилцуулга маягаар бэлтгэн хүргүүлж ажилласан.</p>	
1.4	Хэвлэл мэдээллийн байгууллагаар салбарын үйл ажиллагааг шуурхай сурталчлах, мэдээллэх	Үйл ажиллагааны зардал	Нийтэд түгээсэн мэдээллийн тоо цахим сайтаар нийтэд түгээсэн мэдээлэл	30	30	Боловсролын салбарын хүрээнд хийсэн ажлын мэдээллийг тухай бүрд орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагаар шуурхай сурталчлан ажиллаа. Мөн үндэсний телевиз, мэдээллийн хэрэгслээр сургууль, цэцэрлэгийн тэргүүний 6 үйл ажиллагааг нийтэд хүргэв. Боловсролын салбарын үйл ажиллагааг түгээх “Бид Ховдын хүүхдүүд”, “Тогтвортой хөгжлийн боловсрол”, “Багшийн хөгжил-Ховд БШУГ, цахим сайтуудаар мэдээллээ сургалчлав.	100
1.5	Иргэд, олон нийтийн байгууллагын өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэх	Үйл ажиллагааны зардал	Хугацаанд нь шийдвэрлэсэн өргөдөл гомдлын хувь	100	100	2022 оны жилийн эцсийн байдлаар 80 ширхэг өргөдөл гомдлыг ирснийг хугацаанд нь шийдвэрлэсэн.	100
1.6	Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх	Үйл ажиллагааны зардал	Арга хэмжээний тоо хэрэгжилтийн хувь	4 100	4 100	АНУ-ын ЭСЯ-ны англи хэлний багш сурагчдыг чадваржуулах “Ментор”, Аксесс, Флекс хөтөлбөр, ОХУ-ын Уралын их сургуулийн хөдөөгийн орос хэлний багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, Японы Жайка, Солонгосын Койка сан Японы хүүхдийг ивээх сангийн төслүүд амжилттай хэрэгжиж байна. Аксесс хөтөлбөр 10 дахь удаагийн шинэ элсэлтээ авч хичээллэж эхэллээ. Флекс хөтөлбөр баруун бүсийн 6 дахь сонгон шалгаруулалтаа зохион байгуулж 3 дугаар шатанд Ховд аймгаас 3 хүүхэд тэнцлээ.	100
1.7	Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх,	Үйл ажиллагааны зардал	Салбарын төсөв, хөрөнгө оруулалтын	100	100	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2024 онд шинээр, өргөтлөлийн барилга саналыг 5 дугаар сарын 01-ны дотор АЗД зөвлөлийн хурлаар орж Сангийн яамны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн нэгдсэн цахим системд үр ашиг,	100

	хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах		төлөвлөлтийн хэрэгжилтийн хувь			хэрэгцээ шаарлага, цаашид гарах урсгал зардлын төсөвт үзүүлэх нөлөөлөл зэрэг шинжилгээг хийж зураг төсөв, урт болон дунд, богино хугацааны бодлого нийцэж буй зэргийг хангасан эсэх мэдээллийн оруулан хүргүүлсэн. Үүнд:Жаргалант сумын 8 дугаар сургууль /640 суудал/, 4 дүгээр цэцэрлэг өртгөтгөл/150 ортой/, 2 дугаар цэцэрлэгийн шинэ барилга /150 ортой/, 2 дугаар сургуулийн гал тогооны барилга, Аймгийн 10 сургуулийн үдийн хоолны гал тогооны барилга зэрэг 5 санал хүргүүлсэн. Мөн сургууль, цэцэрлэг, дотуур байранд нэн шаардлагатай тавилга, тоног төхөөрөмжийн мэдээллийг хавсралтаар гарган аймгийн засаг дарга, Боловсрол, шинжлэх ухааны яаманд хүргүүлсэн. Орон нутгийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх засвар, тоног төхөөрөмж, хөтөлбөрүүдэд 19 төсөл арга хэмжээний саналыг зураг, төсөв, эдийн засгийн тооцоо судалгааг гарган аймгийн нийгмийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн. Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар батлагдсан төсөл арга хэмжээний зураг, төсөв, ажлын даалгавар, худалдан авах ажиллагаа, гүйцэтгэлийн хяналт, хүлээн авах ажлыг Аймгийн ЗДТГ, Нийгмийн бодлого, Хөгжлийн бодлого, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, сургууль, цэцэрлэгүүдтэй хамтран төлөвлөж, хэрэгжилт зохион байгуулан ажиллав. Мөн нэн шаардлагатай тоног төхөөрөмж, зөөлөн эдлэл, тавилга мэдээлэл судалгааг гарган БШУЯ, БЕГ, Олон улсын ТИКА, Японы хүүхдийг ивээх санд хүсэлт хүргүүлээд байна.	
1.8	Байгууллагын дотоод аудит хийх	Үйл ажиллагааны зардал	Арга хэмжээний тоо хэрэгжилтийн хувь	2 100	3 100	Байгууллагын эд хөрөнгийн тооллого эхлүүлэн хийж байна. Бүх эд хөрөнгийг цахим тооллогын системд бүртгэх ажил явагдаж байна. Ажилд шинээр орсон болон ажлаас гарсан албан хаагчдын хөрөнгийг нэг бүрчлэн шалгаж хүлээн авч хүлээлгэн өгөх ажлыг хугацаанд нь зохион байгуулж байна. Мөн байгууллагын дотоод журамын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	70

Төлөвлөгөөг үнэлсэн:

Сургалтын бодлогын хэрэгжилт, тусгай зөвшөөрөл,
ББ олголт хариуцсан ахлах мэргэжилтэн
(албан тушаал)

Ахлах мэргэжилтэн

(гарын үсэг)

/Т.Бат-Өлзий/

(огноо)

2022.11.25

БАЙГУУЛЛАГЫН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭГ ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН АЖЛЫН ХЭСГИЙН ДҮГНЭЛТ

Байгууллагын даргын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/77 тоот тушаалаар байгуулагдсан байгууллагын болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх ажлын хэсэг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан аргачлалыг мөрдлөг болгон ажиллалаа.

Байгууллагын хэмжээнд нийт 18 зорилт, чиг үүргийн хүрээнд 81 арга хэмжээ төлөвлөгдсөний гүйцэтгэлийн дундаж 91,8%-тай байна.

ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

№	Зорилт, чиг үүрэг	Зорилгын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн хувь
1	Бодлогын зорилт	1	5	100.0
2		2	4	88.8
3		3	5	62.0
4		4	5	86.6
5		5	2	95.0
6		6	1	50.0
7		7	4	90.0
8		8	3	93.3
9		9	3	93.3
10		10	2	90.0
11		11	3	80.0
	Бүгд	11	37	84.5
12	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилт	1	2	90.0
13		2	4	90.0
14		3	9	93.7
15		4	7	96.4
16		5	6	81.7
	Бүгд	5	28	90.4
17	Хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, зорилт	1	8	96.3
18	Хуулиар олгосон чиг үүрэг, зорилт	1	8	96.3
19		18	81	91.8

Дээрх үнэлгээнээс харахад бодлогын зорилтын 3 дугаар зорилго, чадварлаг багш, сурагч, окутан дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн 3, 4 дүгээр үйл ажиллагаа тасалдсан байна. Үүний учир нь ахмад багш нарын холбооны тэргүүн өвчтэй удаан байсан, солигдсон санхүүжилт шийдэгдээгүй, мөн залуу багш нарын холбооны үйл ажиллагаа идэвхгүй, санхүүжилт байхгүй байсан зэргээс шалтгаалж үйл ажиллагаа тасарсан, 6 дугаар зүйлийн 1 дүгээр заалт Стандарттай Ховд дэд хөтөлбөрийн хэрэгжилт эрчимтэй хийгдээгүй бага оноо авсанаас, 80 гаруй хувьтай үнэлэгдсэн бодлогын хэрэгжилтийн 2 дугаар зорилго, 4 дүгээр зорилт, 11 дүгээр зорилт, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилтын 5 дугаар зорилтууд байна.

